



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН
БАНК



2006
Жилийн тайлан

Агуулга

- 2 Гүйцэтгэх захирлын илгээлт
- 4 Санхүүгийн үзүүлэлтүүд
- 5 Жилийн онцлох үйл явдлууд
- 6 Банкны салбар 2006 онд
- 8 Банкны тухай товч
- 12 Удирдлага зохион байгуулалтын бүтэц
- 14 Байгууллагын банкны үйл ажиллагаа
- 17 Иргэдийн банкны үйл ажиллагаа
- 23 Олон улсын банкны үйл ажиллагаа
- 26 Жижиг дунд бизнесийн банкны үйл ажиллагаа
- 27 Хөрөнгө зохицуулалт, арилжааны үйл ажиллагаа
- 30 Эрсдлийн удирдлага
- 33 Хүний нөөцийн удирдлага
- 34 Ивээн тэтгэлэг, хандивын үйл ажиллагаа
- 35 Хөндлөнгийн хяналтын тайлан
- 77 Салбаруудын хаяг
- 78 Олон улсын харилцаатай банкууд



ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол улсын олон талт, цогц үйлчилгээг үзүүлдэг банкны хувьд байгууллага, жижиг дунд бизнес эрхлэгчид болон иргэдийнхээ эрэлт хэрэгцээнд тулгуурласан, үнэ цэнэ үүсгэсэн банкны шийдлүүдийг бий болгож, хэрэглэгчидийнхээ сэтгэл ханамжийг байнга өндөр байлгахыг зорино. Бидний амжилт нь корпорацийн зөв удирдлага, нийт ажиллагсдын ур чадвар, тэдний чанартай, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх эрмэлзлэл дээр тулгуурлагдана.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ИЛГЭЭЛТ

Эрхэм хүндэт хувь нийлүүлэгчид, харилцагчид үйлчлүүлэгчид, түншүүд, банкны нийт ажиллагсад аа,

Худалдаа Хөгжлийн Банк (ХХБ)-ны Удирдлагын Хорооны нэрийн өмнөөс тус банкны 2006 оны ажлын гүйцэтгэлийг та бүхэнд толилуулах болсондоо нэн баяртай байна.

Тайлант 2006 оны амжилтууд нь ХХБ Монгол улсын банкны салбарт тэргүүлэгч банкны үүргээ амжилттай үргэлжлүүлэн гүйцэтгэж, улс орны эдийн засгийн өсөлт хөгжилтөнд жинтэй хувь нэмэр оруулсаар байгааг баттай илэрхийлж байна. Тайлант онд татварын дараах ашиг 11 773.9 сая төгрөг байгаа нь өмнөх 2005 оны эцэстэй харьцуулбал 59.6 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Нийт актив 40.8 хувиар өсч, 426 292.1 сая төгрөгт хүрлээ.

Банкны үйл ажиллагаа амжилттай үргэлжлэн явагдаж, нэмэлт хөрөнгө оруулалт хийгдсэн тул өөрийн хөрөнгийн бааз суурь улам бэхжиж, 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өөрийн хөрөнгө нийт активын харьцааны үзүүлэлт 18.5 хувь болсон байна. Ингэснээр уг үзүүлэлтийн хувьд Монголбанкнаас тогтоосон зохицтой харьцаа болох 10 хувийг үлмэж давуулан биелүүлж байгаа бөгөөд өөрийн хөрөнгийн үнэмлэхүй дүн нь банкны салбарын нийт өөрийн хөрөнгийн 21 хувийг эзэлж байна.

Том харилцагчдад зориулсан үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлж, улс орны эдийн засгийн тэргүүлэх зэргийн зээлдэгчийн байр сууриа бэхжүүлсээр байгаа бөгөөд тайлант онд том байгууллагуудад олгосон зээлийн дүн 50.3 хувиар өсч, 188 321 сая төгрөгт хүрсэн байна.

Гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас ХХБ-нд зориулан нээсэн худалдааны санхүүжилтийн зээлийн шугамын хэмжээ 3 дахин нэмэгдэж, 86 сая амдолларт хурсэн бөгөөд экспорт, импортын санхүүжилтийн чиглэлээр хэд хэдэн гэрээг байгуулав. Түүнчлэн ХХБ нь Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-ийн Дэлхийн Нийтийн Худалдааг Дэмжих Хөтөлбөр (ДНХДХ)-т хамрагдсан Монгол улсын анхны банк боллоо. Мөн БНХАУ-ын Экспорт болон Зээлийн Даатгалын Корпораци SINOSURE-аас Хятад, Монгол улсуудын хоорондын худалдааны үйл ажиллагааг дэмжих зорилгоор 27 сая амдолларын зээлийн шугамыг 3 жилийн хугацаатай нээв.

Хувийн хэвшил болон Жижиг Дунд Бизнес (ЖДБ)-ийн хөгжлийг дэмжих төрөл бүрийн зээлийн хөтөлбөрүүд, Дэлхийн Банк, Японы Олон Улсын Хамтын

Рандолф Коппа
Гүйцэтгэх захирал



Ажиллагааны Банк (ЯОУХАБ) – наас санхүүжүүлсэн хүрээлэн буй орчныг хамгаалах төслийд дээр амжилттай оролцсоор байна.

ХХБ болон Солонгосын Хөгжлийн Банк (СХБ) – ны хоорондын хамтын ажиллагааг хамтын зээлжүүлэлт, төслийн санхүүжилт, худалдааны санхүүжилт, байгалийн нөөц баялагийг үр бүтээлтэй ашиглах болон бусад бизнесийн чиглэлээр өргөн хүрээнд хөгжүүлэх Харилцан Ойлголцлын Санамж Бичиг (ХОСБ) – т 2006 оны 11 дүгээр сард гарын үсэг зурлаа.

Тус банк нь иргэдэд зориулсан банкны үйлчилгээндээ үрьд өмнөхөөс илүү анхаарч ажиллаж байгаа бөгөөд арилжааны зээл олголтыг нэмэгдүүлэн, түүнийг хүргэх сувгуудыг боловсронгуй болгож, банкны үйлчилгээний технологийн дэвшилтэт бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлж байна. Тайлант онд иргэдэд зориулсан зээлийн хэмжээ өмнөх оноос 37.2 хувиар өсч, 39 831 сая төгрөгт хүрлээ. Хадгаламжийн хэмжээ 57.1 хувиар нэмэгдэж, 123 430.4 сая төгрөгт хүрсэн байна.

ХХБ нь карт болон түүний дагалдах бүтээгдэхүүнүүдийн чиглэлээр ч зах зээл дэх тэргүүлэгч байр сууриа хадгалан ажиллаж байгаа бөгөөд бүтээгдэхүүнүүдийг боловсронгуй болгон сайжруулж, улмаар шинэ төрлийн картуудыг нэвтрүүлж байна. Зах зээлд шинээр гаргасан картын тоо хэмжээний хувьд 2006 он нь өндөр амжилтын жил байсан бөгөөд 27 000 картыг шинээр гаргаж, нийт гаргасан картын тоо 76 000 – д хүрлээ. Энэ нь өмнөх 2005 онтой харьцуулахад 56 хувиар өссөн үзүүлэлт байв. Зах зээлд гаргасан картын тоо хэмжээгээ нэмэгдүүлэхийн зэрэгцээ бизнесийн хүрээгээ өргөжүүлж, MasterCard –ын үндсэн гишүүн боллоо.

Монголулсын банк санхүүгийн зах зээлд банкны IP POS, IPPoS, цахим нэхэмжлэхийн үйлчилгээ, мессеж банкны үйлчилгээ, Хатагтай карт, Мобиком компанийт хамтарсан урамшууллын карт зэрэг технологийн дэвшилтэт бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэв. Түүнчлэн арилжааны хөрөнгө оруулалтын данс, Сингапур долларын харилцах, төлбөр тооцоо зэрэг шинэ үйлчилгээнүүдийг нэвтрүүллээ. Харилцгчийн үйлчилгээний тав тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор Дугаар зохицуулагч машиныг шинээр суурилуулав.

ХХБ нь 2006 онд олон улсын нэр хүнд бүхий үнэлгээний агентлаг болох Moody's Investors Service – ээр кредит үнэлгээ хийлгэсэн бөгөөд ингэснээр уг үнэлгээг

хийлгэсэн Монгол улсын анхны банк болсон юм. Тус агентлаг нь ХХБ – д урт болон богино хугацааны гадаад валютаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зэрэглэлийн хувьд B2, урт болон богино хугацааны дотоод валютаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зэрэглэлийн хувьд Ba2, урт болон богино хугацааны гадаад валютын үнэлгээ авагч байгууллагын хувьд Ba2, урт болон богино хугацааны дотоод валютын үнэлгээ авагч байгууллагын хувьд Ba2, банкны санхүүгийн чадамжийн хувьд D үнэлгээг өгч, нийт зэрэглэлүүдээр банкны үйл ажиллагаа тогтвортой гэж үнэлсэн байна. Улмаар энэ үнэлгээ нь Монгол улсын Засгийн газрын авсан үнэлгээнээс дээгүүр байгаа нь үнэлгээ тогтоолгогчдын хувьд байдаг ховорхон тохиолдуудын нэг болжээ.

Дэлхийд тэргүүлэгчдийн нэг Moody's агентлагаас кредит үнэлгээ авсан нь ХХБ – ны нэр хүндийг олон улсын түвшинд үлмэж нэмэгдүүлсэн явдал болсон бөгөөд тайлант оны сүүлээс эхлэн Голланд улсын ING банктай хамtran ажиллаж, олон улсын санхүүгийн зах зээл дээр бонд гаргах 150 сая ам.долларын хөтөлбөрийг Монгол улсаас анх удаа хэрэгжүүлж эхэлснээс, эхний 75 сая ам.долларын бондыг амжилттай борлуулаад байна.

Тус банк өнгөрсөн хугацааны баялаг түршлага, Монгол улсын зах зээлд эзэлсэн хүчирхэг байр сууриндаа түшиглэн цаашдын ирээдүйгээ төлөвлөж байна. Тайлант онд 2009 оныг хүртэл хэрэгжүүлэх Стратеги төлөвлөгөөгөө боловсронгуй болгож, шинэчлэн баталлаа.

Түүнчлэн бид ажилтнуудын санаачлагыг нэмэгдүүлэх урамшууллын шинэ системийг нэвтрүүллээ. Хамт олны нэгдэл, нягтрал, тодорхой зорилго, тэдэнд зориулсан үр дүнтэй хөшүүрэг нь бизнесийн амжилтын үрдчилсан нөхцөл гэдэгт бид итгэдэг.

Бид цаашдын ирээдүйгээ өөдрөгөөр харж, хувь нийлүүлэгчид, хамtran ажиллагч түншүүд, харилцагч үйлчилгүүлэгчидтэйгээ бий болгосон гүнзгий ойлголцол, найрсаг уур амьсгал, тэднээс бидэнд өгсөн итгэл найдвар нь өмнөө тавьсан зорилгоо амжилттай биелүүлэх бат бэх хөрс суурь болно гэдэгт итгэж байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд

Сая төгрөгөөр	2004	2005	2006
Орлого зарлагын тайлангийн хураангуй			
Хүүний орлого	16 163,1	21 892,4	36 037,3
Цэвэр хүүний орлого	11 901,4	15 601,0	21 448,4
Үйл ажиллагааны орлого	17 662,6	22 670,1	30 310,4
Цэвэр ашиг	5 356,8	7 378,7	11 773,9
Хураангуй тэнцэл			
Актив хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө, банк болон санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	60 976,7	82 781,6	134 943,0
Зээл, урьдчилгаа, үнэт цаас	87 031,9	156 727,5	240 106,1
Бусад	36 264,6	63 269,2	51 243,0
Нийт актив	184 273,2	302 778,3	426 292,1
Пассив хөрөнгө			
Харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	135 373,7	226 233,2	324 669,4
Банк болон санхүүгийн байгууллагуудын хөрөнгө	14 372,0	23 213,1	36 041,2
Бусад пассивууд	2 125,0	5 723,0	6 561,5
Хоёрдогч өглөг	9 672,0	9 768,0	9 320,0
Нийт пассив	161 542,7	264 937,3	376 592,1
Өөрийн хөрөнгө			
22 730,5	37 841,0	49 700,0	
Нийт пассив болон өөрийн хөрөнгө	184 273,2	302 778,3	426 292,1
Зохистой харьцааны үзүүлэлтүүд			
Өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа (>10%)	27,0%	22,1%	18,5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа (>18%)	41,0%	49,7%	27,5%
Гадаад валютын ханшийн эрсдэл (<10%)	0,4%	0,6%	1,5%
Зээлийн төвлөрлийн эрсдлийн харьцаа (<20%)	17,2%	19,8%	14,8%
Холбогдох этгээдийн зээлийн төвлөрлийн эрсдлийн харьцаа (<5%)	0,3%	0,1%	0,1%
Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд			
Өөрийн хөрөнгийн өгөөж	23,6%	19,5%	23,7%
Активын өгөөж	2,9%	2,4%	2,8%

Жилийн онцлох үйл явдлууд

- Байгууллагын зээлийн багцын хэмжээ 2005 онтой харьцуулахад 50.3 хувиар өсч, 188 321 сая төгрөгт хүрлээ.
- Иргэдийн зээлийн багцын хэмжээ 2005 онтой харьцуулахад 37.2 хувиар өсч, 39 831 сая төгрөгт хүрлээ.
- Жижиг Дунд Байгууллагын Банкны Газар (ЖДББГ) –ыг Байгууллагын Банкны Газар (ББГ) –аас тусгаарлан байгуулав.
- Омнөх 2005 онтой харьцуулахад хадгаламжийн хэмжээ 57.1 хувиар өслөө.
- Монгол улсын банк санхүүгийн зах зээлд банкны IP POS, IP POS, цахим нэхэмжлэхийн үйлчилгээ, үндсэн дүнг хамгаалах үйлчилгээ, мессеж банкны үйлчилгээ, "Хатагтай" карт, Мобиком компанийт хамтарсан урамшууллын карт, арилжааны хөрөнгө оруулалтын данс, Сингапур долларын харилцах, төлбөр тооцооны үйлчилгээ, дугаар зохицуулагч машин зэрэг дэвшилтэт бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэв.
- ОУСК-ийн ДНХДХ-т хамрагдсан Монгол улсын анхны банк боллоо.
- БНХАУ-ын Экспорт болон Зээлийн Даатгалын Корпорацийн SINOSURE хөтөлбөрт хамрагдаж, Хятад, Монгол орнуудын хоорондын худалдааг дэмжих 27 сая ам.долларын зээлийн шугамыг нээлгэв.
- Олон улсын банк санхүүгийн байгууллагад нээлгэсэн худалдааны санхүүжилтийн шугамын хэмжээ 2005 онтой харьцуулахад 3 дахин өсч, 86 сая ам.долларт хүрэв.
- ХХБ болон БНСҮ-ын СХБ-ны хоорондын Стратегийн түншлэлийг өргөн хүрээнд хөгжүүлэх ХОСБ – т гарын үсэг зурлаа.
- "Bloomberg" системийг нэмж ашигладаг болсноор олон улсын хөрөнгийн зах зээлийн мэдээллийг нэмэлт сувгаар авч эхэллээ.
- Зах зээлд гаргасан картын тоо 2005 онтой харьцуулахад 56 хувиар нэмэгдэж, 76 000-д хүрлээ.
- MasterCard-ын үндсэн гишүүн болов.
- Картын удирдлагын системийг боловсронгуй болгож, зээлийн картыг Монгол улсын зах зээлд анх удаа гаргах нөхцлийг бүрдүүлэв.
- VISA International-тэй хамтран жуулчдад зориулсан зуны урамшууллыг амжилттай зохион байгуулав.
- Нийт гүйлгээнүүдийг амжилттай буюу алдаа засваргүй хийснийг үнэлэн АНУ-ын Citibank –аас "Хүлээн зөвшөөрөгдсөн чанар – 2006" шагналын эznээр шалгаруулав.
- Банкны үйлчилгээний цар хүрээг тэлж, "Гурван гал", "Сөүл" салбаруудыг шинээр байгууллаа.

Банкны салбар 2006 онд

Мөнгөний нийлүүлэлт 1.5 их наяд (триллион) төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 396.4 тэрбум төгрөг буюу 34.8 хувиар нэмэгдлээ. Мөнгөний нийлүүлэлт болон түүний бүрэлдэхүүн болох бараг мөнгө, М1 мөнгө өмнөх онтой ойролцоо хувиар өсчээ.

Нийт мөнгөний өсөлтөд бараг мөнгөний өсөлт сүүлийн жилүүдэд давамгайлсаар байна. Ялангуяа, банкуудын хадгаламжийн өсөлт мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдэхэд гол нөлөөг үзүүлж байна. Бараг мөнгө нь гадаад валютын харилцах, иргэд байгууллагын төгрөг болон валютын хадгаламжаас бүрддэг бөгөөд тайлант оны эцэст 1.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 333.6 тэрбум төгрөг буюу 38.3 хувиар өссэн байна. Сүүлийн жилүүдэд бараг мөнгөний жилийн өсөлтөд төгрөгийн хадгаламжийн өсөлт зонхицж байна. Энэ нь иргэдийн үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэл сайжирч байгаа болон банкуудын төгрөгийн хадгаламжаас олох өгөөж нь валютын хадгаламжийн өгөөжөөс өндөр байгаа зэрэгтэй холбоотой юм.

Нийт хадгаламж 995.4 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 323.7 тэрбум төгрөг буюу 48.2 хувиар өсчээ. Тухайлбал, иргэдийн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 284.6 тэрбум төгрөг буюу 44.6 хувиар өсч 923 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тайлант оны эцсийн байдлаар М1 мөнгө 331.9 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 62.8 тэрбум төгрөг буюу 23.3 хувиар өсчээ. М1 мөнгөний жилийн өсөлтийн 52.2 хувь нь банкнаас гадуурхи мөнгөний өсөлт, 47.8 хувь нь иргэд, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэх өсөлт байна.


Банкнаас гадуурхи мөнгө гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 75.5 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3.9 нэгжээр буурсан байна. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх оны мөн үеэс 53.4 тэрбум төгрөг буюу 27.9 хувиар тус тус нэмэгдэж, 245.1 тэрбум төгрөгт хүрчээ.

Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, нийт мөнгөний 73.4 хувь нь гадаад цэвэр активт, 26.6 хувь нь дотоод цэвэр активт тус тус байршиж байна. Өнгөрсөн оны мөн үеийн байдлыг авч үзвэл, нийт мөнгөний 50 хувь нь гадаад цэвэр активт, 50 хувь нь дотоод цэвэр активт байршиж байжээ.


Тайлант оны эцэст банкны салбараас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн хэмжээ 2005 оны мөн үеэс 363.4 тэрбум төгрөг буюу 42.3 хувь, өнгөрсөн сарынхаас 41.9 тэрбум төгрөг буюу 3.5 хувиар тус тус өсч, 1.2 их наяд төгрөгт хүрчээ. Нийт зээлийн үлдэгдлийн 92.4 хувийг хэвийн зээл, 2.7 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 4.9 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. Харин өмчлөгчөөр нь авч үзвэл, нийт зээлийн 53.9 хувь нь хувийн салбарт олгосон зээл, 41.5 хувь нь иргэдэд олгосон зээл, 3 хувь нь улсын салбарт олгосон зээл, 1.5 хувь нь бусад санхүүгийн бус байгууллагад олгосон зээл, 0.1 хувь нь бусад санхүүгийн байгууллагад олгосон зээл байна.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сарынхаас 2.7 нэгжээр буурч жилийн 24.5 хувьд, валютынх 1.1 нэгжээр өсч 15.5 хувьд тус тус хүрчээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төгрөгийн зээлийн хүү 3.8 нэгжээр буурсан бол валютын зээлийн хүү 0.7 нэгжээр өссэн байна. Харин 2000 онтой харьцуулахад төгрөгийн зээлийн хүү 10.2 нэгжээр, валютын зээлийн хүү 10.3 нэгжээр тус тус буурчээ. Төв банкны үнэт цаасны хүү өмнөх сарынхаас 0.3 нэгжээр буурсан бол өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.7 нэгжээр өсч жилийн 6.42 хувьд хүрэв.


Банкны салбарын нийт активтээ зэлэх
ХХБ-ны хувь




Банкны салбарын нийт татан төвлөрүүлсэн
хөрөнгөд зэлэх ХХБ-ны хувь



Банкны салбарын нийт зээлд зэлэх
ХХБ-ны хувь



Банкны салбарын нийт өөрийн хөрөнгөд зэлэх
ХХБ-ны хувь



Банкны үнэлгээ



Moody's Investors Service

ҮХ/БХ Татан төвлөрүүлсэн хөрөнгө (гадаад валютаар)

B2/NP

ҮХ/БХ Татан төвлөрүүлсэн хөрөнгө (дотоод валютаар)

Ba2/NP

ҮХ/БХ Үнэлгээ авагч байгууллагын зэрэглэл (гадаад валютаар)

Ba2/NP

ҮХ/БХ Үнэлгээ авагч байгууллагын зэрэглэл (дотоод валютаар)

Ba2/NP

Барьцаагүй үнэт цаас (гадаад валютаар)

Ba2

Хоёрдогч үнэт цаас (гадаад валютаар)

Ba3

Хэтийн төлөв тогтвортой

Банкны тухай товч

ХХБ нь Монгол улсад үйл ажиллагаагаа явуулдаг 16 банкуудын хамгийн том нь бөгөөд 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт актив 426 292.1 сая төгрөг, өөрийн хөрөнгө 49 700 сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт зах зээлийн 22.4, 16.9 хувийг тус тус эзэлж байна. ХХБ нь улс орны банк санхүүгийн зах зээлийн тэргүүлэгч төдийгүй эдийн засгийн хөгжилд хамгийн их хувь нэмрийг оруулагч юм. Банкны гол харилцагчид нь Монгол улсын том аж ахуйн нэгжүүд болон ЖДБ эрхлэгчид бөгөөд богино, дунд, урт хугацааны зээл, хөрөнгө зохицуулалт, гадаад төлбөр тооцоо зэрэг банкны олон талт үйлчилгээг үзүүлдэг. ХХБ нь нийт актив хөрөнгө, зээл олголт, өөрийн хөрөнгийн хувьд банк санхүүгийн зах зээл дээр тэргүүлэгч байр суурийг эзэлж байна.

Өнөөдрийн байдлаар олон улсын түвшинд хүрсэн банк санхүүгийн 60 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг мэргэжлийн чадварлаг 600 гаруй боловсон хүчин, Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Дорноговь аймгууд, Замын-Үүд, Зүүнхараа сумд дахь нийт 18 салбаруудаараа дамжуулан хамгийн орчин үеийн техник технологи ашиглан хүргэж байна. Татварын дараах ашгийн хэмжээ байнга нэмэгдэж ирсэн бөгөөд 2004 онд 5 375.3 сая төгрөг, 2005 онд 7 378.7 сая төгрөг, 2006 онд 11 773.9 сая төгрөг тус тус байлаа.

ХХБ нь 1990 онд 100 хувийн төрийн өмчлөлтэйгээр байгуулгадаж, үйл ажиллагаагаа эхэлсэн Монгол Улсын арилжааны ууган банк юм. Тус банкны 24 хувь нь 1998 онд өөрийн ажиллагсад болон бусад иргэдэд хувьчлагдсан бөгөөд Засгийн Газрын эзэмшиж байсан үлдэх 76 хувийн өмчлөх эрхийг 2002 оны 12 дугаар сард Globull Investment and Development Inc. (SCA) буюу Швейцарь улсын Banca Commercial Lugano, АНУ-ын Gerald Metals Inc нарын хамтарсан консорциум худалдан авсан байна. Улмаар 2004 онд Азийн хөгжлийн Банк (АХБ) болон ОУСК тус банкны 3 сая ам.долларын хувьцааг худалдан авч, 8 сая ам.долларын захиран зарцуулах эрхтэй зээлийг 5 жилийн хугацаатай олгосноор банкны өөрийн хөрөнгөнд нийт 11 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. Энэ нь олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагууд Монгол улсын банкны салбарт хөрөнгө оруулсан анхны үйл явдал болсон юм.

Банкны удирдлагыг 2002–2006 оны хооронд Голланд улсын дэлхийд алдартай ING банк хэрэгжүүлсэн бөгөөд энэ хугацаанд ХХБ Монгол Улсын банк санхүүгийн салбар дахь тэргүүлэгч байр сууриа хадгалан ажиллахын зэрэгцээ олон улсын зах зээлд үйл ажиллагаагаа тэлсэн байна.

ХХБ нь олон улсын 80 гаруй банк санхүүгийн байгууллагуудтай корреспондент харилцаа тогтоосон бөгөөд ING Bank N.V., HSBC Bank N.A., Bank of Tokyo-Mitsubishi UFJ Ltd, Dresdner Bank AG, Citibank N.A, American Express Bank Ltd, Commerzbank AG зэрэг олон улсын төлбөр тооцоогоор тэргүүлэгч 22 банкинд корреспондент данстай. Энэ харилцаа нь тус банкийг дэлхийн гол валютуудаар төлбөр тооцоо явуулах, хөрөнгө, эх үүсвэрийн талаарх онлайн мэдээллүүдийг харилцагчдад хүргэх өргөн боломжуудаар хангаж байна.

ХХБ нь Монгол улсын олон улсын худалдааны гол санхүүжүүлэгчдийн нэг бөгөөд жижиглэнгийн болон бөөний худалдаа, хүнс, нефтийн импорт, уул уурхай, тээвэр, барилга зэрэг эдийн засгийн төрөл бүрийн салбаруудын бизнест үйлчилдэг. Тус банк нь нийт банкны системийн хэмжээнд хамгийн их гадаад актив эзэмшигч бөгөөд гадаад валютын төлбөр тооцооны 50 хувийг гүйцэтгэдэг арилжааны зах зээлийн тэргүүлэгч юм.

ХХБ 2000 онд Монгол Улсын банкны системд анх удаа алтны арилжаа эрхлэх зөвшөөрлийг авснаас хойш дотоодын алтны зах зээл дээр тэргүүлэгч байр суурийг эзэлж ирсэн билээ. Улмаар 2004 онд Монгол Улсын арилжааны банкуудаас хамгийн анх гадаадад алт экспортлох үйл ажиллагааг эхлүүлж, алтны арилжаанаас олох ашиг орлогын хэмжээг үлэмж нэмэгдүүлсэн юм. Алт олборлогч харилцагч үйлчлүүлэгчдийг ханшийн эрсдлээс хамгаалах зорилготой алтны опцион, форвард, биет алт барьцаалсан форвард ба захиалгат арилжаа зэрэг ахисан төвshний санхүүгийн цогц үйлчилгээнүүдийг үзүүлж байна.

ХХБ нь иргэдэд зориулсан банкны бүтээгдэхүүн үйлчилгээгээ өргөжүүлэхэд урьд өмнөхөөс түлхүү анхаарах болсон бөгөөд арилжааны зээл олголтыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх сувгуудыг боловсронгуй болгон, технологийн дэвшилтэтбүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлж байна. Харилцагч үйлчилгээнүүдийг зориулж олон улсын SWIFT сүлжээнд холбогдсон, хоёр шатлалт хамгаалалт бүхий интернэт банкны үйлчилгээ, GSM, CDMA сүлжээний аль алины хэрэглэгчдийн хувьд боломжтой SMS банкны үйлчилгээ Монгол улсын банк санхүүгийн зах зээлд анх удаа нэвтрүүллээ. Картын бизнесийн чиглэлээр тэргүүлэгч байр сууриа хадгалан ажиллахыг зорьж байгаа бөгөөд бүтээгдэхүүнүүдийг боловсруулан сайжруулж, шинэ төрлийн картуудыг нэвтрүүлж байна. Тоо хэмжээ нь үлэмж хурдтай өсч буй карт эзэмшигчидээ үзүүлэх санхүүгийн үйлчилгээний үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор Loyalty хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. ХХБ нь American Express, VISA, Mastercard, JCB зэрэг дэлхийд тэргүүлэгч бүх картуудаар төлбөр хүлээн авах боломжийг харилцагчиддаа олгодог цорын ганц банк юм. VISA картын үйлчилгээний нэг хэсэг болох бэлэн мөнгөний машин ATM-ийг Монгол Улсад анх удаа нэвтрүүлсэн бөгөөд хамгийн олон ATM-тэй банк болно. Энгэрөгч оны эцсийн байдлаар 24 цагийн турш байнгын ажиллагаатай ATM Улаанбаатар хотод 36, хөдөө орон нутагт 4 байна.

ХХБ нь 2006 онд олон улсын нэр хүнд бүхий үнэлгээний агентлаг болох Moody's Investors Service-ээр кредит үнэлгээ хийлгэсэн бөгөөд ингэснээр уг үнэлгээг хийлгэсэн Монгол улсын анхны банк боллоо. Банкны авсан үнэлгээ Монгол улсын Засгийн Газрын авсан үнэлгээнээс дээгүүр байгаа нь үнэлгээ тогтоолгогчидын хувьд байдаг ховорхон тохиолдлуудын нэг болсон юм.

Сүүлийн үеийн ололт амжилтууд

- 2006 "Хүлээн зөвшөөрөгдсөн чанар 2006" (АНУ-ын Citibank-ны шалгаруулалтаар)
- 2005 "Оны Шилдгэ Арилжааны Банк" (Монголбанкны шалгаруулалтаар)
- 2003 "Маркетингийн Үйл Ажиллагааг Гарамгай Хэрэгжүүлэгчийн шагнал"
(VISA International байгууллагын шалгаруулалтаар)
- 2002 "Монгол Улсын Тэргүүлэгч Банк" (The Banker сэтгүүлийн шалгаруулалтаар)
- 2001 "Монгол Улсын Тэргүүлэгч Банк" (The Banker сэтгүүлийн шалгаруулалтаар)
- 2001 "Шинэ Зах Зээл Хөгжүүлэгчийн шагнал" (VISA International-ийн шалгаруулалтаар)

Төлөөлөн Удирдах Зөвлөл

[Дарга](#)

Д. Эрдэнэбилэг

[Гишүүд:](#)

Д. Мөнхбаатар

Ч. Энхболд

Т. Болдхүү

Т. Цолмон

Удирдлагын хороо

Рандолф Коппа
Гүйцэтгэх захирал

О. Орхон
Гүйцэтгэх захирлын орлогч

П. Мөнхсайхан
Үйл ажиллагаа хариуцсан гүйцэтгэх захирал



Захирлын зөвлөл

Даан Коппиян

Эрсдлийн удирдлага хариуцсан гүйцэтгэх захирал

Д. Отгонбилэг

Захирал, Дотоод Аудитын Газар

Ж. Батaa

Захирал, Хөрөнгө Зохицуулалтын Газар

Э. Энхболд

Захирал, Үйл Ажиллагааны Газар

Ш. Энхтөр

Захирал, Эрхзүйн Зохицуулалтын Газар

Н. Нямсүрэн

Захирлын үүрэг гүйцэтгэгч, Байгууллагын Банкны Газар

М. Баярмагнай

Захирал, Жижиг Дунд Байгууллагын Банкны Газар

З. Хайдар

Захирал, Иргэдийн Банкны Газар

Ө. Олонсүрэн

Захирал, Эрсдлийн Удирдлагын Газар

Д. Янжмаа

Захирал, Санхүүгийн Бүртгэл, Хяналтын Газар

Б. Үлэмж

Захирал, Санхүүгийн Байгууллагын Газар

А. Мөнхбаясгалан

Захирал, Маркетинг Судалгааны Газар

Г. Тэгшбүрэн


Захирал, Хүний Нөөцийн Газар

Д. Даваатулга

Захирал, Хамгаалалт Аюулгүй Байдлын Газар



Үдирдлагага зохион байгуулалтын бүтэц





Миний
санхүүгийн
хангалттай нөөц

Байгууллагын банкны үйл ажиллагаа

ХХБ нь Монгол улсын байгууллагын банкны зах зээлийн тэргүүлэгч бөгөөд эдийн засгийн голлох салбарууд болох уул уурхай, шатахууны импорт, барилга, аж үйлдвэр, эрчим хүч, тээвэр, харилцаа холбоо, худалдаа болон банк санхүүгийн байгууллагуудад дээд зэрэглэлийн банкны үйлчилгээг хүргэдэг. Байгууллагын банкны үйл ажиллагаа тайлант онд урьд өмнөх жилүүдийн адилаар эрчимтэйгээр өсч, харилцагч зээлдэгчдэд хүргэх бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдсэний зэрэгцээ санхүүгийн онцлог хэрэгцээг хангах шинэ хувилбаруудыг бий болгож, олон улсын зах зээлээс хуримтлуулсан туршлагадаа түшиглэн мэргэжлийн зөвлөгөөг өгч ажиллалаа.

Байгууллагуудад зориулсан уламжлалт санхүүжилтийн дүн өсөхийн зэрэгцээ хүү шимтгэлийн орлого болон худалдааны санхүүжилт эрчимтэй нэмэгдсэн нь ББГ-ын ажилтнуудын харилцагч үйлчилгээг хүргэх эрмэлзлэлийг илэрхийлж байна.


Тайлант оны эцсээр ББГ-ын олгосон зээлийн нийт үлдэгдлийн хэмжээ 188 321 сая төгрөг байгаа нь банкны нийт зээлийн өрийн үлдэгдлийн 76.9 хувь болж байна. Энэ нь өмнөх 2005 оны эцэст зээлийн өрийн үлдэгдэл 125 276 сая төгрөг байсантай харьцуулахад 50.3 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Олгосон зээлийн дундаж хэмжээ 1 335.9 сая төгрөг байв.

Байгууллагын харилцагчдын харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл 130 256.8 сая төгрөг байв.

Зээлийн багц эрчимтэй нэмэгдсэн нь ББГ-ын хүүний орлогыг нэмэгдүүлэв. Тус газрын 2005 онд олсон хүүний орлогын хэмжээ 13 275.9 сая төгрөг байсан бол тайлант онд 19 045.5 сая төгрөг болж өмнөх оноос 43.4 хувиар өсчээ.


Банкны хөрөнгийн бааз суурь бэхжин нэмэгдэж, зээлжих чадвар болон нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ, хугацааг өсгөж чадсан нь зээлийн багц нэмэгдэхэд нөлөөлөв.

Байгууллагын зээлийн өсөлт
(тэрбум төгрөгөөр)




Улмаар уул уурхай, шатахуун, аж үйлдвэр, худалдааны салбарт оруулах хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр зээлийн нийт багцад эзлэх 4–8 жилийн хугацаатай санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн байна.

Багц дахь зээлийн хугацаа 2005, 2006 онуудад



Улс орны бизнесийн төрөл бүрийн салбаруудын голлох аж ахуйн нэгжүүдийг үйлчилж санхүүжүүлж байгаа нь тус банкны дотоодын эдийн засгийн өсөлт хөгжилтөнд оруулах хувь нэмрийг бататгаж байгаа юм. Тайлант оны эцсээрх зээлийн өрийн үлдэгдлийг салбаруудын ангиллаар харуулбал:



Байгууллагын харилцагч зээлдэгчиддээ бэлэн мөнгөний удирдлага, гүйвуулга зэрэг үйлчилгээг цогцоор үзүүлэхээр зорьж ажилласан нь хүү шимтгэлийн орлогыг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болсон байна.

Түүнчлэн тайлант оны туршид худалдааны санхүүжилтийн хэмжээ үлэмж нэмэгдлээ. ХХБ нь ОУСК-ийн ДНХДХ-т хамрагдсан Монгол улсын анхны банк болсон юм. Энэ хөтөлбөрийн хүрээнд 3 хүртэл жилийн хугацаатай, 5 сая ам.долларын санхүүжилтийн эрх нээлгэж, худалдааны санхүүжилтийг одоо харилцаатай байгаа улс орон, банкууд дээр нэмж илүү өргөн хүрээнд явуулах боломжтой болсон байна.

[Худалдааны санхүүжилтийн өсөлт \(сая ам.доллараар\)](#)

Худалдааны санхүүжилт	2004	2005	2006
Импортын аккредитив	17.18	46.32	51.12
Экспортын аккредитив	3.79	7.4	7.65
Батлан даалт	1.95	3.41	4.25
НИЙТ	22.92	57.13	63.02

Харилцагч үйлчлүүлэгчдийн бизнес өргөжиж, зээлийн эрэлт ихэссэн, өөрийн хөрөнгийн бааз суурь нэмэгдсэнээр нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ өссөн, Монгол улсын эдийн засаг 8.4 хувь өссөн зэрэг нь ХХБ-ны байгууллагын банкны үйл ажиллагаа өргөжин тэлэхэд нөлөөлсөн байна.

Иргэдийн банкны үйл ажиллагаа

ХХБ-ны Иргэдийн банкны үйл ажиллагаа нь харилцагч байгууллагуудынхаа ажилтан, албан тушаалтнууд болон дунд, түүнээс дээш түвшний орлоготой хувь иргэдэд чиглэгддэг.

Тус банк нь иргэдэд зориулсан банкны бүтээгдэхүүн үйлчилгээгээ өргөжүүлэхэд урьд өмнөхөөс түлхүү анхаарах болсон бөгөөд арилжааны зээл олголтыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх харилцагчийн үйлчилгээний шууд болон шууд бус сувгууд (салбар нэгжүүд, ATM, POS-үүд, г.м)-ыг нэмэгдүүлэх, техник, технологийн дэвшилтээ арга хэрэгсэлүүдийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Зээлийн үйлчилгээ

Иргэдэд зориулсан зээлийн багцын үлдэгдэл 2006 оны эцэст 39 831 сая төгрөг байсан нь банкны нийт зээлийн багцын үлдэгдлийн 16.3 хувийг эзэлж байна. Энэ нь өнгөрөгч оны эцэст байсан 26 002.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй харьцуулбал 37.2 хувиар өссөн үзүүлэлт болжээ.


Зээлийн багц үлэмж хэмжээгээр өссөн нь Иргэдийн Банкны Газар (ИБГ)-ын хүүний орлогыг нэмэгдүүлж, 2005 оны эцэст 5 429.4 сая төгрөг байсан бол 2006 оны эцэст 8 468.4 сая төгрөг болж нэмэгдэн, 55.9 хувиар өсчээ.

Бизнесийн зээл, орон сууцны зээл зэрэг бүтээгдэхүүнүүдийн харилцагчадад хүргэх нөхцлийг илүү таатай болгож, хүүг бууруулсан нь зээлийн багцыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болсон байна.

Автомашины зээлийн санхүүжилт нэмэгдэж, хамтран ажиллаж байсан 9 байгууллага дээр нэмж 3 нийлүүлэгч байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүллээ.

Түүнчлэн зээлийн бүтээгдэхүүнүүдийн төрлийг нэмэгдүүлж, хадгаламж барьцаалсан зээл, цалингийн зээл зэрэг шинэ бүтээгдэхүүнүүдийг гаргав.

Иргэдийн зээлийн өсөлт
(тэрбум төгрөгөөр)



Иргэдэд зориулсан зээлийн
багцын бүтэц



Хадгаламж

ХХБ нь өөрийн харилцагчиддаа зориулж хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн төрөл бүрийн бүтээгдэхүүнүүдийг санал болгодог бөгөөд үүнд уламжлалт, нөхцөлт, урьдчилсан хүйт, хүүхдийн хадгаламж зэрэг бүтээгдэхүүнүүд багтаж байна.

Тайлант онд хадгаламжийн хэмжээ 52 898 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 123 430.4 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оны эцэстэй харьцуулахад 75 хувиар өссөн үзүүлэлт болжээ.

Түүнчлэн хугацааны сонголттой хадгаламж, хэрэглээний хадгаламж зэрэг шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд гаргахад бэлтгэв.

Шинэ бүтээгдэхүүнүүд


ХХБ нь бүтээгдэхүүнүүдийнхээ нэр төрлийг байнга нэмэгдүүлж боловсронгуй болгон, зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахын зэрэгцээ өөрийн бүтээгдэхүүнүүдээр дамжуулан санхүүгийн зах зээлийн шинэ эрэлтийг үүсгэж бий болгож байна. Шинэ бүтээгдэхүүнүүд нь орчин үеийн дэвшилтэт технологид үндэслэдэг бөгөөд үйл ажиллагааны цар хүрээ, газар зүйн байрлал, ажлын цагийн хуваарь, харилцагч үйлчилгүүлэгчдийн тооноос үл хамааран үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, гүйлгээ өгөгдлийг өндөр хурдтайгаар боловсруулах ажлыг шинэ түвшинд гаргаж байна.

Тайлант 2006 он нь банкны бүтээгдэхүүн үйлчилгээний багц, нэр төрлийг өргөжүүлж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд арвин их амжилтын жил байлаа. Тус онд ХХБ Монгол улсын банк санхүүгийн зах зээлд банкны IP POS, IP POS, цахим нэхэмжлэхийн үйлчилгээ, үндсэн дүнг хамгаалах үйлчилгээ, CDMA системийн мессеж банкны үйлчилгээ, Хатагтай карт, Мобиком компанитай хамтарсан урамшууллын карт, дугаар зохицуулагч машин зэрэг технологийн дэвшилтэт бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэв.

IP POS гэдэг нь TCP/IP протоколд суурилсан, үйлчилгээний байгууллагууд дээр картаар гүйцэтгэх төлбөр тооцоог хурдасгах програм хангамжийн цогц шийдэл юм.

Цахим нэхэмжлэхийн үйлчилгээ нь харилцагч үйлчилгүүлэгчдийг орон сууц, цахилгаан, гар утас зэрэг тогтмол хийгддэг төлбөрүүдийг харилцагчийг банкин дээр ирүүлэлгүйгээр автоматаар, интернэтээр дамжуулан хийх боломжоор хангадаг санхүүгийн бүтээгдэхүүн юм.

Хадгаламжийн өсөлт (тэрбум төгрөгөөр)



GSM, CDMA системийн аль алинд тохиромжтой мессеж банкны үйлчилгээ нь харилцах болон картын дансуудынхаа үлдэгдлээ гар утаснаасаа шалгах, ханшийн мэдээлэл авах зэрэг олон төрлийн үйлчилгээг авах боломжоор хангадаг.

Хатагтай картыг зах зээлд гаргаснаар ХХБ нь өөрийн эмэгтэй харилцагч нараа тэдний хамгийн их үйлчлүүлэх дуртай үйлчилгээний байгууллагуудын хямдралтай үйлчилгээнд хамруулах өргөн боломжийг нээлээ.

Түүнчлэн Монгол улсын хөдөлгөөнт холбооны хамгийн том оператор болох Мобиком корпорацитай хамтран урамшууллын хамтарсан картыг зах зээлд гаргав. Уг картыг гаргаснаар ХХБ болон Мобиком компорацийн хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлж, банкны харилцагчид үйлчлүүлсэн дүнгийнхээ хэмжээгээр хурийтуулсан оноондоо тохируулан Мобиком корпорацийн үнэгүй бэлэг болон үйлчилгээг сонгох эрхтэй боллоо.

Дугаар зохицуулагч машинтай болсон нь харилцагч үйлчлүүлэгчидээ олон улсын хэм хэмжээнд төгс нийцсэн үйлчилгээ үзүүлэх орчин нөхцлийг бий болгох банкны үйл ажиллагааны нэг хэсэг юм.

Интернэт банкны үйлчилгээ

ХХБ нь Монгол улсын салбарт мессеж банкны үйлчилгээ, факсаар төлбөр хийх үйлчилгээ, 24 цагийн ажиллагаатай дуудлагын төв, интернэт банк, цахим нэхэмжлэх, ATM-үүд зэрэг биет бус сувгаар хүргэх хамгийн олон төрлийн үйлчилгээнүүдийг үзүүлж байна. Энэ бүхэн нь харилцагч үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, тэдний банкаар үйлчлүүлэх зардлыг бууруулан, бүтээгдэхүүн үйлчилгээ авах нөхцлүүдийг хялбар, энгийн болгож байна.


ХХБ нь олон улсын SWIFT сүлжээнд холбогдсон, хоёр шатлалт хамгаалалттай интернэт банкны үйлчилгээ, GSM, CDMA сүлжээний аль алины хэрэглэгчдийн хувьд боломжтой мессеж банкны үйлчилгээ зэргийг Монгол улсын зах зээлд анх нэвтрүүлсэн юм. Тус банкны ИБГ-ын харилцагчдын 20 орчим хувь нь мессеж банкны үйлчилгээг авдаг бөгөөд харилцагчдын тоо тогтмол нэмэгдэж байна.

Түүнчлэн ХХБ нь ATM-ийг Монгол улсад анх удаа нэвтрүүлсэн, хамгийн том сүлжээ бүхий банк бөгөөд тайлант онд энэ үйлчилгээг Улаанбаатар хот дахь 36, хөдөө орон нутаг дахь 4 машинаар дамжуулан хүргэлээ. Мэдээллийн технологийн өндөр хурдтай хөгжил нь үйлчилгээ үзүүлэхэд тав тухтай, хялбар, олон төрлийн боломжтой, хямд зардалтай ATM-үүд ойрын ирээдүйд банкны салбаруудыг орлож, 24 цагийн туршид үйлчилгээ үзүүлэх боломжийг олгох болно гэж үзэж байна.

Карт болон мөнгөн гүйвуулгын үйлчилгээ

ХХБ нь одоо байгаа бүтээгдэхүүнүүдийг улам боловсронгуй болгож, шинэ төрлийн картуудыг зах зээлд гаргах замаар картын үйлчилгээний зах зээлд тэргүүлэгч байр сууриа хадгалан ажиллахыг зорьж байна.

Карт эзэмшигчдийн тооны өсөлт



Тус банк нь дэлхийн картын зах зээлд тэргүүлэгч VISA, American express, MasterCard, JCB картуудыг Монгол улсын нутаг дэвсгэр дээр төлбөрт хүлээн авдаг цорын ганц банк юм. Тайлант он нь зах зээлд гаргасан картын тооны хувьд онцгой амжилтын жил байсан бөгөөд 27 000 шинэ карт гаргаснаар карт эзэмшигчдийн тоо 76 000-д хүрч, өмнөх оны эцсээс 56 хувиар өссөн байна.

Зах зээлд гаргасан картын тоо хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тус банк энэ чиглэлийн бизнесийн хүрээгээ өргөтгөж, MasterCard-ийн үндсэн гишүүнээр элсэн, VISA картын агент банкуудын сүлжээг өргөжүүллээ.

ХХБ нь өөрийн харилцагчиддаа тав тухтай, найрсаг үйлчилгээ үзүүлэхийг ямагт эрмэлзэж бөгөөд энэхүү зорилтын хүрээнд биет бус сувгийн бүх үйлчилгээнүүдийг дээд зэргийн түвшинд хүргэж, харилцагч үйлчлүүлэгчдэд хялбар болгох зорилгоор онлайн үйлчилгээнүүдийг боловсронгуй болгов.

Хэрэглээний зах зээлийн өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээнд зориулж Loyalty системийг шинээр суурилуулсан бөгөөд ингэснээр Монгол улсын үүрэн холбооны зах зээлийн тэргүүлэгч Мобиком компанийтай хамтарсан урамшууллын картыг гаргалаа. Энэ чиглэлийн төслүүдийг цаашид ч үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Картын үйлчлүүлэгч харилцагч нартай тогтоосон холбоогоо улам нягтуулж, эрэлт хэрэгцээг нь илүү сайн мэдэх зорилгоор үйлчилгээний байгууллагуудын уулзалтыг зохион байгуулав. Үйлчилгээний байгууллагуудад зориулсан төлбөр тооцооны үйлчилгээний зэрэгцээ ЖДБ эрхлэгчид болон иргэдийн банкны харилцагчиддаа зориулсан шинэ бүтээгдэхүүнүүдийг гаргав.

Өмнө зах зээлд гаргасан, нэмүү өртгийг бий болгогч бүтээгдэхүүнүүд, интернэт төлбөр тооцоо, урьдчилсан төлбөрт утасны картыг ATM-ээр худалдах зэрэг үйлчилгээнүүдийн найдвартай ажиллагааг илүү өндөр түвшинд болгож сайжруулав.


Монгол улсын үүрэн холбооны үйлчилгээний зах зээлийн шинэ оролцогч болох UNITEL компанитай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж, урьдчилсан төлбөрт, цэнэглэгч картуудыг өөрийн ATM-ын сүлжээгээр борлуулах боллоо.

VISA International байгууллагатай хамтран Монгол улсад ирж буй VISA карт хэрэглэгч жуулчдад зориулсан зуны урамшууллыг зохион байгуулав.

ХХБ нь олон улсын мөнгөн гүйвуулгын MoneyGram үйлчилгээг Улаанбаатар хот болон хөдөө орон нутаг дахь сүлжээгээр, Монгол Шуудан, Капитрон, Анод, Эрэл, Хадгаламж, Хас, Улаанбаатар хотын банк зэрэг агент банкуутдай хамтран үзүүлдэг бөгөөд уг үйлчилгээний програм хангамжийг үндсэн мэдээллийн сантай шууд харьцааж, гүйлгээний түүхийг шалгах боломжтой, илүү өндөр хамгаалалт бүхий DeltaWorks системээр шинэчиллээ.

Агент банкуутдай тогтоосон амжилттай хамтын ажиллагааны дунд MoneyGram үйлчилгээгээр хийгдсэн гүйвуулгын жилийн дундаж хэмжээ 2005 онд 13.5 сая ам.доллар байснаа 2006 онд 20.4 сая төгрөг болж өмнөх жилээс 51.1 хувиар нэмэгдсэн байна.

MoneyGram үйлчилгээгээр хийгдсэн гүйвуулгын хэмжээ (сая ам.доллараар)





Дэлхийтэй холбогдох
таны санхүүгийн гүүр

Олон улсын банкны үйл ажиллагаа

Тайлант онд ХХБ нь олон улсын зах зээл дэх байр сууриа бэхжүүлж, гадаад улсын хамтран ажиллагч түншүүдтэйгээ тогтоосон харилцаа холбоог шинэ, өндөр түвшинд хүргэлээ.

Тус банк нь 2006 оны 8 дугаар сард Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)–ийн Дэлхий нийтийн худалдааг дэмжих хөтөлбөр (ДНХДХ)–т хамрагдсан бөгөөд ингэснээр уг хөтөлбөрт оролцогч Монгол улсын анхны банк болсон байна. Хөтөлбөрийн хүрээнд ХХБ 3 хүртэл жилийн хугацаатай, 5 сая ам.долларын санхүүжилтийн эрхтэй болж, худалдааны санхүүжилтийг илүү олон улс орон, санхүүгийн байгууллагуудыг хамарсан өргөн хүрээнд хийх болов. Түүнчлэн БНХАУ–ын Экспорт болон Зээлийн Даатгалын Корпораци SINOASURE–aac Хятад, Монгол улсуудын хоорондын худалдааны үйл ажиллагааг дэмжих зорилгоор 27 сая ам.долларын зээлийн шугамыг 3 жилийн хугацаатай нээлээ. ХХБ Солонгос, Тайван улсуудын Экспорт Импортын Банк зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг санхүүжилтын хөтөлбөрүүдийг үргэлжлүүлсээр байна. Тайлант оны эцсийн байдлаар гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас ХХБ–нд зориулан нээсэн худалдааны санхүүжилтийн зээлийн шугамын хэмжээ өмнөх жилтэй харьцуулахад 3 дахин нэмэгдэж, 86 сая ам.долларт хүрэв. Шууд болон барьцаагүй зээлийн шугамуудын дүн өссөнөөр ХХБ–ны худалдааны санхүүжилтийн боломж газар нутгийн болон нийт хэмжээний хувьд өсөн нэмэгдэж, энэ чиглэлийн бизнесийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулсаар байна.

Тус банк Дэлхийн Банк, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк (ЯОУХАБ)–наас санхүүжүүлсэн хувийн хэвшил болон ЖДБ–ийн хөгжлийг дэмжих төрөл бурийн дамжуулан зэрлжүүлэлтийн хөтөлбөрүүд, байгаль орчныг хамгаалах төслүүдэд амжилттай оролцож, 35 сая ам.долларын санхүүжилтийг 10 хүртэл жилийн хугацаатайгаар авах боллоо.

Тайлант онд олон улсын нэр хүнд бүхий үнэлгээний агентлаг болох Moody's Investors Service–ээр Монгол улсын банк санхүүгийн байгууллагуудаас анх удаа кредит үнэлгээ хийлгэж, олон улсын түншүүддээ итгэл найдвартай хамтран ажиллагч гэдгээ баталлаа. Энэхүү үнэлгээгээр урт болон богино хугацааны гадаад валютаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зэрэглэлийн хувьд B2, урт болон богино хугацааны дотоод валютаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зэрэглэлийн хувьд Ba2, урт болон богино хугацааны гадаад валютын үнэлгээ авагч байгууллагын хувьд Ba2, урт болон богино хугацааны дотоод валютын үнэлгээ авагч байгууллагын хувьд Ba2 үнэлгээнүүдийг авч, нийт зэрэглэлүүдээр банкны үйл ажиллагаа тогтвортой гэж дүгнэгдсэн байна. Улмаар энэ үнэлгээ нь Монгол улсын Засгийн газрын авсан В1 үнэлгээнээс хоёр зэрэглэл дээгүүр байгаа нь банкны нэр хүндийг олон улсын түвшинд өргөсөн явдал боллоо. Энэхүү үнэлгээнд түшиглэн ХХБ олон улсын зах зээлд бонд гаргаж, хөрөнгө татан төвлөрүүлэхэд тайлант оны эцсээс эхлэн бэлтгэж эхэлсэн бөгөөд 2007 оны I дүгээр сард Голланд улсын дэлхийд алдартай ING банктай хамтран, Монголуулсаас анх удаа олон улсын санхүүгийн зах зээл дээр бонд гаргах Европын Дунд Хугацааны Үнэт Цаас

(ЕДХҮЦ)-ны 150саяам.долларын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс эхний хэсэг болох 2010 онд эргэн төлөгдөх 8.625 хувийн хүйтэй 75 сая ам.долларын бондыг амжилттай борлууллаа. Тус хөтөлбөрт Moody's Investor Service-ийн зүгээс гадаад валютаар гаргасан барьцаагүй үнэт цаасны Ba2, гадаад валютаар гаргасан хоёрдогч үнэт цаасны Ba3 үнэлгээнүүдийг тус тус өгсөн байна. Энэхүү бондыг гаргасан нь олон улсын санхүүгийн зах зээлд үнэт цаас гаргаж, хөрөнгө татан төвлөрүүлсэн Монгол улсын анхны тохиолдол бөгөөд ХХБ-ны олон улсад явуулах ўйл ажиллагаандaa гаргасан том амжилтуудын нэг болсон юм. Улмаар зах зээлд гаргасан бондын захиалга арилжигдах дүнгэсээ хэд дахин давж, Сингапур (37 хувь), Хонгконг (25 хувь), Их Британи (17 хувь), Европын зарим орнууд (16 хувь), АНУ-ын оффшорууд (5 хувь) зэрэг 13 орны 96 хувь нийлүүлэгчид худалдан авсан байна. Хөрөнгө оруулагчдын бүтэц нь хөрөнгө оруулалтын сангүүд (42 хувь), иргэдийн болон хувийн жижиглэнгийн болон хувийн банкны байгууллагууд (38 хувь), санхүүгийн байгууллагууд (17 хувь), тэтгэврийн сангүүд (3 хувь) зэргээс бүрдэж байна. Энэхүү арилжаагаар ХХБ тавьсан зорилтуудыг давуулан биелүүлж, хөрөнгө оруулагчид, өрсөлдөгчид, хэвлэл мэдээллийнхний зүгээс өндөр үнэлгээ авсан байна.




Түүнчлэн ХХБ нь тайлант онд өөрийн томоохон түншүүддээ зориулж, гадаадын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран хэд хэдэн хамтын санхүүжилтийг зохион байгуулав. Мөн Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөлийн Орнуудын банкуудад зориулж нэр хүнд бүхий гадаадын бусад банк санхүүгийн байгууллагуудаас олон улсын зах зээл дээр зохион байгуулсан хамтын зээлжүүлэлтийн ўйл ажиллагаанд үргэлжлүүлэн оролцлоо.

Улмаар 2006 оны 11 дүгээр сард ХХБ болон Солонгосын Хөгжлийн Банк (СХБ)-ны хоорондын хамтын ажиллагааг хамтын зээлжүүлэлт, төслийн санхүүжилт, худалдааны санхүүжилт, байгалийн нөөц баялгийг

үр бүтээлтэй ашиглах болон бусад бизнесийн чиглэлээр өргөн хүрээнд хөгжүүлэх Харилцан Ойлголцлын Санамж Бичигт гарын үсэг зурлаа.

Хамтын зээлийн өсөлт (сая ам.доллараар)



A portrait of a smiling man wearing traditional Mongolian attire. He is wearing a large, light-colored fur hat and a red jacket with black embroidery and decorative elements. A blue garment is visible underneath. He is also wearing a purple sash or belt. The background is plain white.

Миний санхүүгийн
хамгийн сайн
дэмжигч бөгөөд зөвлөгч

Жижиг дунд бизнесийн банкны үйл ажиллагаа

Улс орон бурийн өсөлт хөгжилтөнд ЖДБ-ийн гүйцэтгэх үүрэг нэн их болохыг дэлхийн олон орны эрдэмтэд, улс төрчид, санхүүчид хүлээн зөвшөөрдөг.


ХХБ нь ЖДБ эрхлэгчдэд зориулсан үйл ажиллагаагаа амжилттай өргөжүүлж, тайлант онд Жижиг Дунд Байгууллагын Банкны Газар (ЖДББГ)-ыг ББГ-аас тусгаарлан байгууллаа.

Энэ арга хэмжээний дунд 2006 онд ЖДБ эрхлэгч харилцагчдын тоо өмнөх оноос 85 хувиар өсч, зээлийн багцын хэмжээ 16 864 сая төгрөгт хүрсэн байна.

ХХБ нь ЖДБ-ийн санхүүжилтийг зөвхөн өөрийн дотоод эх үүсвэрээр төдийгүй, олон улсын банк санхүүгийн байгууллагудаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөр бүрдүүлж байгаа бөгөөд ингэнээр харилцагчиддаа хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцлүүдийг илүү тааламжтай болгож байна.

Тус банк Дэлхийн Банк, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк (ЯОУХАБ)-наас санхүүжүүлсэн хувийн хэвшил болон ЖДБ-ийн хөгжлийг дэмжих төрөл бурийн дамжуулан зээлжүүлэлтийн хөтөлбөрүүд, байгаль орчныг хамгаалах төслүүдэд амжилттай оролцож, 35 сая ам.долларын санхүүжилтийг 10 хүртэл жилийн хугацаатайгаар авах боллоо.

**ЖДБ-ийн зээлийн өсөлт
(тэрбум төгрөгөөр)**



Түүнчлэн Тайван, Солонгос улсуудын Экспорт Импортын Банктай хамтарсан хувийн хэвшлийг дэмжих хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд тус банк өөрийн ЖДБ-ийн харилцагчид Тайван болон Өмнөд Солонгос улсуудтай хийх худалдааны эргэлтийг дэмжих хямд өртөгтэй эх үүсвэрээр хангах боломжоор хангаж байна.

ХХБ нь ОУСК-тай хамtran ЖДБ эрхлэгчдийг банктай хамtran ажиллах, үйл ажиллагаагаа удирдан явуулахад нь туслах зорилготой SME toolkit тусгай веб хуудсыг ажиллуулж байна. Энэхүү веб хуудсанд хандсанаар тус банкны ЖДБ эрхлэгч харилцагчид үйл ажиллагаагаа төлөвлөх, удирдах, борлуулалт маркетингийн үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг авах боломжтой юм.

Бид ЖДБ-ийн харилцагчидтайгаа тогтоосон амжилттай хамтын ажиллагааны дунд тэднийг том харилцагчдын эгнээнд ойрын ирээдүйд дэвшүүлэн хөгжүүлэх болно гэдэгтээ итгэлтэй ажиллаж байна.

Хөрөнгө зохицуулалт, арилжааны үйл ажиллагаа

ХХБ-ны үйл ажиллагаагаа амжилттай өргөжихийн зэрэгцээ хөрөнгө зохицуулалтын үйл ажиллагаа ч хүчтэй хэвээр байж, улс орны зах зээл дэх тэргүүлэгч байр сууриа хадгалсаар ирлээ.

Тайлант онд банкны хөрөнгө зохицуулалт, арилжааны үйл ажиллагаанд нэн тэргүүнд тавигдах зорилтууд бол мөнгөний зах зээл, валюту арилжаа, алтны бизнесийн дотоодын зах зээлд тэргүүлэгч байр сууриа бэхжүүлэх явдал байв. Банкны санхүүгийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх замаар ашиг орлогыг нэмэгдүүлээд зогсохгүй харилцагч үйлчлүүлэгчидээ ахисан төвшний санхүү, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх замаар тэдний санхүүгийн удирдлагыг үр ашигтай болгох нэхцлийг бүрдүүлэхэд зорин ажиллалаа. Улмаар харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээг боловсронгуй болгож сайжруулах санаачлагуудыг гаргав.


Гадаад валютын арилжаа

ХХБ нь Монгол улсын банкны салбарын хэмжээнд хамгийн их гадаад актив эзэмшигч, гадаад валютын төлбөр тооцооны 50 хувийг гүйцэтгэдэг арилжааны зах зээлийн тэргүүлэгч бөгөөд дэлхийн санхүүгийн зах зээлийн голлоо 13 валютаар арилжаа хийдэг. Сингапур долларын харилцах, төлбөр тооцооны үйлчилгээг 2006 онд шинээр нэвтрүүлсэн.

Тайлант онд олон улсын валютын зах зээлд ханшны хэлбэлзэл их байсан боловч ХХБ форвард, своп, опцион зэрэг санхүүгийн дэвшилтэд хэрэгслүүдийг ашиглан гадаад болон дотоодын зах зээл дээрх арилжааны үйл ажиллагаагаа идэвхижүүлж чадлаа. Харилцагч үйлчлүүлэгчидээ банкны бүх салбар нэгжүүдийг хамарсан валютын арилжааны онлайн системээр үйлчлэхийн зэрэгцээ зах зээлийн шинэ сэргэг мэдээллээр хангаж ажиллав. Энэ бүхний дунд валютын арилжааны эргэлтийг нэмэгдүүлж, арилжааны ашгийн хэмжээ 2 583.8 сая төгрөгт хүрлээ.

Тус банк нь валютын арилжаанаас хүлээж болзошгүй эрсдлийг бууруулж, эргэлтийг нэмэгдүүлэхийн тулд санхүүгийн шинэ бүтээг-дэхүүнүүдийг бий болгож нэвтрүүлэхэд байнга анхаардаг билээ.

ХХБ-ны валютын арилжааны зах зээлд эзлэх хувь



Энэ ажлын хүрээнд хөшүүрэгт арилжаа хийх үйлчилгээг хөгжүүлсэн нь харилцагчдын зүгээс ихээхэн талархал хүлээсэн үйл явдал болов. Түүнчлэн олон улсын санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг харилцагчиддаа зориулж, эрсдлийг бууруулахад туслах арилжааны хөрөнгө оруулалтын дансны үйлчилгээг нэвтрүүллээ.

Харилцагч үйлчлүүлэгчдэд төгрөг, евро, ам.доллар, иений болон алтны дансуудаа барьцаалан ашиг олох боломжийг олгодог маржин арилжаа өргөжлөө.

Алтны арилжаа


ХХБ нь Монгол улсын арилжааны банкуудаас анх удаа, 2000 онд алтны арилжаа эрхлэх зөвшөөрөл авснаас хойш дотоодын зах зээл дээрх алтны арилжаанд тэргүүлэх байр суурин хадгалж, үйл ажиллагаагаа жил тутам өргөжүүлж ирлээ. Улмаар Монгол Улсын арилжааны банкуудаас хамгийн анхлан гадаад зах зээлд алт экспортлох үйл ажиллагааг эхлүүлж, алтны арилжаанаас олох ашиг орлогын хэмжээг үлэмжк нэмэгдүүлсэн юм. Харилцагчдын тоо байнга өсөн нэмэгдэж байгаа бөгөөд 2006 оны байдлаар Монгол улсад алт олборлогч 130 аж ахуйн нэгжийн 70-аас илүү нь тус банкны харилцагчид байна. Алт олборлогч харилцагчдын ханшийн эрсдлийг бууруулах, богино хугацааны санхүүгийн хэджинг хийхэд нь туслах зорилгоор алтны опцион, форвард, биет алт барьцаалсан форвард ба захиалгат арилжаа зэрэг ахисан төвшний санхүүгийн цогц үйлчилгээнүүдийг үзүүлж байна.

Тус банк нь харилцагч үйлчлүүлэгчиддээ мөнгөн хөрөнгөө алтанд байршуулах, хөрөнгө оруулах, санхүүгийн менежментийн хэрэгсэл болгон ашиглах боломж олгодог, биет бус алтаар байршсан алтны дансыг Монгол улсын банк санхүүгийн зах зээлд анх гаргасан бөгөөд мөнгөний дансыг гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

Түүнчлэн биет болон биет бус алтны дансыг нэвтрүүлж, алт барьцаалсан зээлийг олгож байна.

Эдгээр шинэ үйл ажиллагаануудын дунд алтны арилжааны цэвэр ашиг тайлант оны эцэст 2 277.7 сая төгрөгт хүрлээ.

ХХБ-ны дотоодын алтны арилжааны зах зээлд эзлэх хувь



Мөнгөн хөрөнгийн удирдлага болон мөнгөний зах зээл дэх үйл ажиллагаа

Тус банкны мөнгөн хөрөнгийн удирдлага нь Монголбанкнаас тогтоосон заавал байлгах нөөцийн шаардлагыг биелүүлэх, богино хугацааны эрэлт хэрэгцээг хангах зорилгоор банкны бэлэн мөнгөний урсгалыг удирдах, зээл, хөрөнгө оруулалтын багцын хөrvөх чадварыг хангах зэрэг үйл ажиллагаануудыг хамардаг. Мөнгөний зах зээлийн гол үйл ажиллагаанд банк хоорондын мөнгөний зах зээл буюу Монголбанк болон Засгийн Газрын үnэт цаасны арилжаанд оролцох, мөнгөний зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэх, хөrvөх чадвартай активуудыг удирдах зэрэг багтана.

ХХБ нь Монголбанк болон Засгийн Газрын үnэт цаасны зах зээлийн хамгийн идэвхтэй оролцогч юм. Хөрөнгө оруулалтын багцын бүтэц сайжирсны дунд 2006 онд эдгээр зах зээлээс олох хүүгийн орлогын хэмжээ нэмэгдлээ.


Зээлийн багцын хэмжээ өссөн нь мөнгөн хөрөнгийн удирдлагыг активт сууринсан удирдлагаас богино хугацааны хөrvөх чадварыг хангах зорилгоор банк хоорондын зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэх боломжтой актив пассив хосолсон удирдлагад шилжих болгов. Мөнгөн хөрөнгийн үr ашигтай удирдлага болон олон улсын мөнгөний зах зээл дээр явуулсан үйл ажиллагаануудын дунд тайлант онд банкны орлого I 860.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Актив пассивын удирдлага

Актив пассивын удирдлагыгхэрэгжүүлэх гол үйл ажиллагаа нь тэнцлийн оновчтой бүтцийг бий болгох замаар хүүгийн цэвэр орлогыг өсгөх, хүүгийн эрсдлийг удирдах, банкны урт хугацааны хөrvөх чадварыг хангах зэрэг юм. Тайлант онд дотоодын зах зээлээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хүr өссөөр байсан ч актив пассивын үr бүтээлтэй удирдлагыг хэрэгжүүлэхэд байнга анхаарсны дунд үйл ажиллагаа үлэмж ахиц дэвшилтэй байлаа. Эдгээрээс дурьдвал:

- Өөрийн хөрөнгийн өсөлт огцом, нийт активын өсөлт алгуур байсан нь хөшүүргийн үзүүлэлтийг бууруулж, улмаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн өртөг багасав.
- Тэнцлийн бүтцийг зохистой болгох үйл ажиллагааны дунд хүүгийн цэвэр орлого 84 хувиар өслөө.
- Банкны санхүүгийн хөшүүргийг сайжруулснаар харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх жилээс 17 хувиар нэмэгдэв.

**ХХБ-ны мөнгөний зах зээлд
эзлэх хувь**



Эрсдлийн удирдлага

Банкны эрсдлийн удирдлагын систем нь үндсэндээ үйл ажиллагаанаас үүдэн гарах үндсэн эрсдлүүд болох зээлийн, зах зээлийн, хүүгийн, хөрвөх чадварын болон үйл ажиллагааны эрсдлийг хянахад төвлөрөн ажилладаг.

Тайлант онд ХХБ-ны эрсдлийн удирдлагын систем үргэлжлэн хөгжиж, нийт эрсдлийг үйл ажиллагааны зорилтуудад заасан хэмжээнд барихад зорин ажиллалаа.

Эрсдлийн удирдлагын стратегийг хэрэгжүүлэх явцад банкны удирдлагын зүгээс Эрсдлийн Удирдлагын Газар (ЭҮГ), Зээлийн Хороо (ЗХ) болон Актив Пассивын Удирдлагын Хороо (АПУХ)-ны үйл ажиллагаанд онцгой анхаарч ажиллав.

Үйл ажиллагааны эрсдлийн удирдлагыг хөгжүүлж хянах зорилгоор ЭҮГ-ын харьянд шинэ хэлтсийг байгуулав.


ЭҮГ-ын зүгээс банкны бүх салбар нэгжүүдэд эрсдлийн шинжээчийг шинээр томилж, зээлийн болон ЖДБ-ийн эрсдлийг үнэлэх сайтар зохион байгуулагдсан бүтцийг бий болгон, зээлийн хяналтыг сайжруулж, салбаруудын үйл ажиллагааны эрсдлийг удирдах боллоо.

Зээлийн эрсдэл

Бизнесамжилттайөсчхөгжихөдээрсдлийнудирдлагынчхолбогдол нэн чухал учир ХХБ нь энэ чиглэлийн ажлууд болон эрсдлийн удирдлагын механизмаа байнга сайжруулж боловсронгуй болгож байдаг билээ. Гол анхаарлыг зээлийн эрсдлийн удирдлагад төвлөрүүлдэг. Энэхүү эрсдлийг хянахын тулд тус банк зээлийн эрсдлийн талаар баримтлах, зээлийн багцын төвлөрөл, нэг болон нэг бүлэг зээлдэгчийн хувьд банкны үүрч болох эрсдлийн хүлээн зөвшөөрөгдөх хэмжээг тогтоосон бодлого, журмуудыг боловсруулан гаргалаа. Зээлдэгчийн эрсдлийн түвшинд тавигдах, салбар, нутаг дэвсгэрийн харьалал болон зээлийн төрлүүдээр ялгаатай хязгаарлалтуудыг ЗХ-ноос баталж, ЭҮГ болон Зээлийн Бүтцийн Өөрчлөлт Хяналтын Хэлтсээс хяналтыг хэрэгжүүлж байна.

Зээлийн эрсдлийн урирдлагыг боломжит зээлдэгчид болон зээл авсан харилцагчдын хүлээсэн үүргээ цаг хугацаандаа биелүүлэх чадварыг тогтмол шинжлэх замаар хэрэгжүүлж байна. Зээл олгох нөхцлүүдийг эрсдлийг бууруулах бодлогод нийцүүлэн өөрчлөөд байна.

Нийт зээлийн багцад чанаргүй зээлийн эзлэх хувь



Эрсдлийг удирдах шат дараалсан, цогц арга хэмжээний дүнд зээлийн багцын чанар мэдэгдэхүйц хэмжээнд сайжирлаа. Жишээлбэл, 2005 оны эцэст нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 7.1 хувь байсан бол 2006 оны эцсээр 4.6 хувь болж буурсан байна.

Зах зээлийн эрсдэл

ХХБ нь хүү, хөрвөх чадвар, ханшийн эрсдлийн удирдлагыг багтаасан зах зээлийн эрсдлийн удирдлагын системийг тасралтгүй сайжруулсаар ирлээ. Энэхүү систем нь төрөл бүрийн үйл ажиллагаа, хэрэгслүүдэд тавих эрсдлийн хязгаарлалтуудыг багтаадаг.

Эрсдэлтэй үнэ цэнийн арга буюу VAR нь зах зээлийн ердийн нөхцөлд санхүүгийн хэрэгслүүдийн үнийн өөрчлөлтөөс үүдэн банкны нийт багцаас алдаж болох алдагдлыг хэмжиж тодорхойлдог. Зах зээлийн ердийн бус нөхцөлд стрессийн шинжилгээний аргыг хэрэглэдэг.

Тайлант оны бодит VaR утгууд (сая төгрөгөөр)

Тайлант он	Хамгийн их VaR утга	Хамгийн бага VaR утга	Дундаж VaR утга
2006	489.7	16.1	277.4

Тус банкны VaR арга нь:

1. Итгэлцлийн түвшинг 99 хувиар авч үздэг.
2. Ажлын сүүлийн 250 хоногийн өгөгдөл тулгуурладаг.
3. Санхүүгийн хэрэгслүүдийн хоорондын үнийн хамаарлыг тооцдог.

Түүнчлэн ХХБ нь өөрийн хэрэглэж буй VaR аргадаа банкны зах зээлийн эрсдлийг үнэн зөв, бодитой хэмжиж байгааг тогтоох зорилгоор буцаан шалгалт хийдэг. Буцаан шалгалтын үр дүн ХХБ Базелийн Хорооны холбогдох журмын дагуу ажиллаж байгааг баталгаажуулсан байна.

Хүүгийн болон хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын удирдлага нь банкны үйл ажиллагаанаас олох ашгийг хамгийн өндөр түвшинд байлгахыг зорихын зэрэгцээ бүх санхүүгийн үүргүүдийг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллахад чиглэгдэв. Тус банкны АПУХ нь тэнцлийн актив, пассивтай холбогдох үйл ажиллагаануудын хэмжээ, хугацаа, хүүний хувьд баримтлах дунд болон урт хугацааны хөрвөх чадварын хязгаарлалтууд, хөрвөх чадварын төлөвийг багтаасан санхүүгийн төлөвлөгөөг хийх зэрэг ажлуудыг хариуцдаг. Богино хугацааны хөрвөх чадварын хувьд үйл ажиллагааны явцын дунд шийдвэрлэх аргыг хэрэглэдэг.

Түүнчлэн ирээдүйн хөрвөх чадварын шинжилгээг хийж, мөнгөн хөрөнгийн орох гарах урсгалын тэнцвэр болон хүлээсэн үүргүүдийг биелүүлэхийн тулд богино хугацаанд төвлөрүүлэх боломжтой активын хэмжээг үнэлж тооцоолдог. Хүүгийн эрсдлийг GAP аргаар шинжлэхдээ нөхцөл байдлын шинжилгээг давхар хийдэг.

Хүүгийн эрсдэл нь санхүүгийн төрөл бүрийн хэрэгслүүдээс олох ашгийн хэлбэлзлийг бий болгоно. Энэ нь хүүгийн орлого, зарлага, актив, пассив хөрөнгийн зах зээлийн үнэлгээний аль алинд нөлөөлдөг. Банкны санхүүгийн үр дүнд үзүүлэх нөлөөллийг бууруулахын тулд актив пассивын орлогын динамикийг тооцон үнэлж, цаашдын төлөвийг нь гарган, хүүний эрсдлээс үүсэх алдагдлыг хамгийн бага түвшинд байлгах актив, пассивын оновчтой бүтцийг баталгаажуулдаг.

Түүнчлэн ХХБ нь зах зээлийн бодит нөхцлийг тусгахын тулд актив, пассивын хүүгээ тухай бүр өөрчилж ажилладаг.

Үйл ажиллагааны эрсдэл

ХХБ нь банкны технологиудыг дэвшилтэт түвшинд байлгаж, бизнесийн үйл явцын дахин инженерчлэлийг хэрэгжүүлэн, эрсдлийг бууруулж, эрх мэдлийн хуваарилалтыг сайжруулах зорилгоор заавар журмуудыг боловсронгуй болгон, үйл ажиллагааны алдагдлаас сэргийлэх ажлуудыг хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд үйл ажиллагааны эрсдлийн удирдлагын өргөн хүрээг хамарсан системийг бий болгож эхлээд байна.

Үйл ажиллагааны эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн үүрэг нь банкны бизнесийн нэгж, салбаруудыг үйл ажиллагааны эрсдлийн удирдлагын бодлогоор хангаж, хэрэгжүүлэх явдал юм. Бодлогоор дараах асуудлуудад голлон анхаардаг. Үүнд:

- Тогтоогдож, хянагдаагүй байгаа эрсдлүүдийг олж илрүүлэх
- Эрсдлүүдийн нөлөөлөл болон ашигт ажиллагааг хэмжих
- Эрсдлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд барихын тулд холбогдох арга хэмжээг авах
- Үйл ажиллагааны эрсдлийг хянах

ХХБ нь хөрөнгө зохицуулалт, зээл, картын үйлчилгээ, татан төвлөрүүлсэн хөрөнгө, ATM-ийн програм хангамжийн эрсдлүүдийг тогтоох, эрсдлүүдийн болон тэдгээрт тавигдах хяналтын нөлөөллийг үнэлэх, зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан эрсдлүүдийг бууруулах арга замуудыг тодорхойлох дотоод заавар журмуудыг бий болголоо.

Хүний нөөцийн удирдлага

ХХБ-ны хүний нөөцийн бодлого нь дэвшүүлсэн бүх зорилт болон үүргүүдийг шуурхай шийдвэрлэж биелүүлэх чадвартай, өндөр мэргэжлийн, нэгдмэл багийг бүрдүүлэхэд зорин ажилладаг. Энэ зорилгын хүрээнд тайлант онд банкны зүгээс ажиллагсдын мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, урамшууллын шинэ системийг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлагын илүү боловсронгуй хэлбэр, аргачлалыг нэвтрүүлэх, байгууллагын соёлыг хамгаалж, хүчирхэгжүүлэхэд идэвх санаачилга гарган ажиллалаа.

Харилцагчдын бааз суурийн төвлөрлийг тархааж, бизнесийн үйл явцыг шулуутгах, ажил үүргийн давхардлыг арилгах, хамтын удирдлагын чанарыг сайжруулах шаардлагуудын хүрээнд банкны хөгжлийн стратеги, нэн тэргүүний зорилтуудад нийцүүлэн бүтэц зохион байгуулалтын болон ажиллагсдын бүтцийг өөрчлөх хэд хэдэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Үйл ажиллагаагаа тэлж, төвлөрлийг сааруулах арга хэмжээнүүдийн дунд салбар нэгжүүдийн сүлжээг өргөжүүлэн, холбогдох боловсон хүчинүүдээр хангаж ажилласнаар тайлант оны эцэст нийт ажиллагсдын тоо 613-т хүрлээ.

Ажиллагсдын идэвх санаачилгыг сэргээх бодлогын хүрээнд урамшууллын шинэ системийг нэвтрүүлэв. Энэхүү шинэ систем нь ажил үүргүүдийн зааг ялгаа, хамаарлыг тодорхой гаргах, ажиллагсдын цалинг ажил үүргийн гүйцэтгэл, хариуцлагын хүрээ, зах зээлийн үнэ цэнээс шууд хамааруулан тогтооход үндэслэлээ.

ХХБ нь ажиллагсдынхаа сургалт, хөгжлийн асуудалд онцгой анхаарал тавьдаг бөгөөд тогтмол явагдах сургалт нь байгууллагын амжилтын салшгүй хэсэг гэдэгтэй санал нэгтэй байдаг. Тайлант онд нийт 150 сургалтанд, 570 гаруй удирдах болон бусад түвшний ажиллагсадыг хамруулж, дотоод, гадаадын сургалтын төвүүд, зөвлөх үйлчилгээний компаниудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлсээр байна.

Тус банк нь өөрийн ажиллагсаддаа санхүүгийн болон буцалтгүй тусlamжийг олгож, тухайн нөхцөлд шаардлагатай дэмжлэгийг үзүүлдэг. Энэ зорилгоор 2006 онд 45 ажилтанд нийт 24.3 сая төгрөгийн тусlamж үзүүлсэн байна. Ажиллагсдын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх зорилгоор ажиллагсдын орон сууцны зээлийн хөтөлбөрийг бий болгосон бөгөөд тайлант онд нийт 72 ажилтан | 360.9 сая төгрөгийн зээл авчээ.

Тус банкны ажил мэргэжлээрээ тэргүүлсэн 10 ажилтан 2006 онд Монгол улсын төр, засгийн шагналуудаар шагнагдсан байна.

Түүнчлэн ХХБ-ны ажилтнуудын “Ёс зүйн дэг”-ийг боловсруулж, банкны өөрийн ажиллагсдаар хянагдах боллоо. Хамт олны багийн уур амьсгалыг төлөвшигүүлэх, нэгдэл нягтралыг сайжруулах спорт, урлагийн уралдаан тэмцээн, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан үдэшлэг, хүлээн авалтыг зохион байгуулж ирэв.

Ивээн тэтгэлэг, хандивын үйл ажиллагаа

ХХБ нь Монгол улсын хамгийн том банкны хувьд улс орны эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд арилжааны үйл ажиллагаагаар төдийгүй, ивээн тэтгэлэг хандивын арга хэмжээгээрээ дамжуулан оролцдог билээ. Банкны санхүүгийн эрүүл саруул байдал нь ивээн тэтгэлэг хандивын хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлсээр ирсэн байна. Соёл, боловсрол, эрүүл мэнд, биеийн тамирын салбарууд, олон нийтийн байгууллагууд нь банкнаас хэрэгжүүлдэг нийгмийн чанартай арга хэмжээнүүдийн хүрээнд санхүүгийн дэмжлэг хүлээн авагчид юм. Тайлант онд ХХБ нийгмийн шинж чанартай үйл ажиллагаа явуулдаг 11 байгууллагад хандив, 21 төсөлд ивээн тэтгэлэг үзүүлж, нийт хандив тусlamжийн хэмжээ 62 сая төгрөгт хүрсэн байна. Банкнаас үзүүлсэн ивээн тэтгэлгийн өндөр ач холбогдолтой арга хэмжээнүүдийн нэг нь Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний ерөнхий ивээн тэтгэгч, түншээр ажилласан явдал байлаа.

ХХБ-ны хандивын бодлогын нэг гол чиглэл нь соёл урлагийн салбарт дэмжлэг үзүүлэх явдал бөгөөд ингэснээр Монгол улсын болон дэлхий дахины соёл урлагийн хөгжилд хувь нэмрээ оруулах зоридог. Тайлант онд тус банк Монголын Урлагийн Зөвлөлөөс эрхлэн явуулдаг телевизийн цуврал нэвтрүүлгийг санхүүжүүлэх, шинэ залуу болон олонд танигдсан хамтлаг дуучид, зохиолч, уран бүтээлчдэд дэмжлэг үзүүлэх ажлуудыг хэрэгжүүллээ. Түүнчлэн ХХБ нь ивээн тэтгэлэг, хандивынхаа хэсгийг тусlamж дэмжлэг хамгийн их шаардлагатай нийгмийн салбарууд, хүүхэд асран хүмүүжүүлэх болох анагаах байгууллагууд, нөхөн сэргээх эмчилгээний төвүүд, нийгмийн хамгааллын байгууллагуудад зориулдаг. Тус банк нь Улаанбаатар хотын Тусгай хэрэгцээт боловсролын сургалт арга зүйн цогцолбор 29 дүгээр дунд сургуулийн хүүхдүүдэд жил бүрийн шинэ жилийн баяраар бэлэг өгч, баяр хүргэдэг уламжлал тогтоод байна.

Биеийн тамир, урлагийн салбарт Засгийн Газрын бодлогыг үр бүтээлтэй хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХХБ нь үндэсний биеийн тамирыг хөгжүүлэх, спортын баг хамтлагуудыг дэмжихэд өндөр ач холбогдол өгдөг. Энэхүү дэмжлэг нь эрүүл амьдарлын хэв маягийг улс орон даяар хэвшүүлэхэд хувь нэмрээ оруулна гэж үздэг. ХХБ нь залуучуудын сагсан бөмбөгийн шигшээ баг, дугуйт тэшүүрийн тамирчид, ширээний тениссид, сурчид, бөхчүүдийг олон улсын уралдаан тэмцээн болон Азийн Олимпийн XV дугаар тогтолцонд оролцоход ивээн тэтгэлэг, тусlamж үзүүллээ. Түүнчлэн биеийн тамирын байгууллагуудад дэмжлэг үзүүлж, зохион байгуулж буй спортын арга хэмжээнүүдийг санхүүжүүлдэг. Энэ ажлын хүрээнд Дугуйт Тэшүүрийн Холбоо, Үндэсний Бөхийн Холбоо, Монголын Хөлбөмбөгийн Холбоо, Оюутны Спортын холбоо зэрэг байгууллагуудтай хамтран ажиллалаа. Монголын Үндэсний Телевизийн техникийн шинэчлэлд зориулж 16,8 сая төгрөгийн хандив үзүүлэв. Амжилттай хэрэгжиж буй санхүүгийн үйл ажиллагаануудынхаа дунд ХХБ нь ивээн тэтгэлэг, хандивын хөтөлбөрүүдээ байнга нэмэгдүүлж, хүрээг тэлэх боломжтой юм. Ивээн тэтгэлэг, хандивын бодлого нь тухайн орон нутгийн нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд оролцох үүднээс банкны бүх салбар, нэгжүүдээр дамжин хэрэгждэг.

ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫН ТАЙЛАН
Худалдаа Хөгжлийн Банк ХХК

2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх
санхүүгийн тайлан

Худалдаа Хөгжлийн Банк ХХК
Компаний мэдээлэл

[Албан хаяг](#)

Жүүлчны гудамж-7

Улаанбаатар-11

Монгол Улс

[Төлөөлөн Удирдах Зөвлөл](#)

Д. Эрдэнэбилэг (2006 оны 12 дугаар сарын 28-нд томилогдсон)

Д. Мөнхбаатар (2006 оны 12 дугаар сарын 28-нд томилогдсон)

Ч. Энхболд (2006 оны 12 дугаар сарын 28-нд томилогдсон)

Т. Цолмон (2006 оны 12 дугаар сарын 28-нд томилогдсон)

Т. Болдхүү (2006 оны 12 дугаар сарын 28-нд томилогдсон)

Фабио Калиа (2006 оны 12 дугаар сарын 28-нд чөлөөлөгдсөн)

Жан Бодуа (2006 оны 12 дугаар сарын 28-нд чөлөөлөгдсөн)

Роберто Бонзи (2006 оны 12 дугаар сарын 28-нд чөлөөлөгдсөн)

Рик Смит (2006 оны 12 дугаар сарын 28-нд чөлөөлөгдсөн)

Дашзэвэг Зоригт (2006 оны 12 дугаар сарын 28-нд чөлөөлөгдсөн)

[Компанийн нарийн](#)

[бичгийн дарга](#)

Д. Даваажав

[Аудиторууд](#)

KPMG

Куала Лумпур

Малайз улс

Тэнцвэр оргил аудит ХХК

Улаанбаатар

Монгол Улс

Захирлууд ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл

Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ны (цаашид Банк гэх) захирлууд болох Д.Эрдэнэбилэг, Д.Мөнхбаатар, санхүүгийн асуудал хариуцсан гүйцэтгэх удирдлагууд болох Рандолф Коппа, Д.Янжмаа бид энэхүү тайлангийн 39–76 дугаар хуудсанд үзүүлсэн 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн болохыг баталгаажуулж байна.

Д. Эрдэнэбилэг
ТУЗ-ийн дарга

Д. Мөнхбаатар
ТУЗ-ийн гишүүн

Рандолф Коппа
Гүйцэтгэх захирал

Д. Янжмаа
Санхүүгийн Бүртгэл,
Хяналтын Газрын захирал

Улаанбаатар, Монгол улс
2007 оны 3 дугаар сарын 9



KPMG (Firm No.AF 0758)
Chartered Accountants
Wisma KPMG
Jalan Dungun, Damansara Heights
50490 Kuala Lumpur, Malaysia



Тэнцвэр Оргил Аудит ХХК
402 тоот, Хатан Сүйх Компанийн байр
ЗӨЧ, 8 хороо, СБДүүрэг
Улаанбаатар, Монгол Улс
Утас/Факс: 976-11-324496

Худалдаа Хөгжлийн Банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Бид 39–76 дугаар хуудсанд үзүүлсэн Худалдаа Хөгжлийн Банкны санхүүгийн тайланд аудит хийллээ. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэж гаргах нь банкны захирлуудын үүрэг байдаг.

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргаж, өөр аливаа нэг зорилгод биш зөвхөн та бүхэнд тайлагнах нь бидний үүрэг юм. Бид энэхүү тайлангийн агууллын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангуудыг материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажилд санхүүгийн тайлангүүд дахь дүн, тодруулгүүдүүн дагалдах нотолгоог түүврийн аргаар шалгах ажиллагаа багтдаг. Мөн аудитын ажилд захирлуудын хийсэн томоохон тооцооллууд ба баримталсан нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг үнэлэх, түүнчлэн санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ зохистой тайлагнагдсан эсэхэд үнэлэлт өгөх ажлууд орно.

Бидний гүйцэтгэсэн аудит нь бидний дүгнэлтэд зохистой үндэслэлийг хангаж өгнө гэдэгт бид итгэлтэй байна.

Бидний дүгнэлтээр 39–76 дугаар хуудсанд үзүүлсэн санхүүгийн тайлангууд нь 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал болон тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв үзүүлсэн байна.

KPMG
Мэргэшсэн нягтлан бодогч
Байгууллагын дугаар:
Улаанбаатар, Монгол Улс

Тэнцвэр Оргил
Мэргэшсэн нягтлан бодогч
AF 0758 Лицензийн дугаар: 056/2006
2007 оны 3 дугаар сарын 09

Худалдаа Хөгжлийн Банк ХХК
2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Тайлан тэнцэл

Актив	Тодруулга	2006 мян.төг	2005 мян.төг
Бэлэн мөнгө	4	25,371,639	11,771,646
Банк санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламж	4	83,842,987	62,183,406
Монголбанк дахь харилцах, хадгаламж	4	25,728,407	8,826,580
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	5	27,584,472	46,598,605
Зээл ба урьдчилгаа	6	240,106,085	156,727,476
Үндсэн хөрөнгө	7	12,225,512	9,735,893
Биет бус хөрөнгө	8	829,942	384,406
Бусад хөрөнгө	9	10,603,078	6,550,261
НИЙТ АКТИВ		426,292,122	302,778,273

Пассив ба өөрийн хөрөнгө

Пассив			
Харилцагчдын харилцах, хадгаламж	10	324,669,447	226,233,195
Бусад банк, санхүүгийн байгууллагуудын харилцах, хадгаламж	11	9,583,124	10,769,825
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авсан зээл	12	26,458,098	12,443,261
Татварын өглөг		1,230,053	851,258
Бусад пассив	14	5,331,398	4,871,696
Нийт хадгаламж, зээл, татвар, бусад өр төлбөр		367,272,120	255,169,235
Хоёрдогч өглөг	13	9,320,000	9,768,000
Нийт пассив		376,592,120	264,937,235
Өөрийн хөрөнгө			
Хувьцаат капитал	15	6,610,113	6,607,477
Бусад нөөц		12,171,762	12,155,904
Хуримтлагдсан ашиг		30,918,127	19,077,657
Нийт өөрийн хөрөнгө		49,700,002	37,841,038
НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		426,292,122	302,778,273

Эдгэр тодруулгүүд нь дээрх санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг ба тэдгээртэй холбон унших ёстой.

Худалдаа Хөгжлийн Банк ХХК

2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулгүүд

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	Тодруулга	2006 мян.төг	2005 мян.төг
Хүүгийн орлого	17	36,037,323	21,892,444
Хүүгийн зардал	18	(14,588,934)	(6,291,421)
Хүүгийн цэвэр орлого		21,448,389	15,601,023
Хураамж шимтгэлийн цэвэр орлого	19	4,576,908	3,583,693
Үйл ажиллагааны бусад орлого	20	4,285,087	3,485,364
Хүүгийн бус цэвэр орлого		8,861,995	7,069,057
Үйл ажиллагааны орлого		30,310,384	22,670,080
Үйл ажиллагааны зардал	21	(12,190,069)	(10,255,523)
Үнэлгээний бууралтын алдагдлын хасагдуулга	22	(1,630,679)	(2,092,626)
Үйл ажиллагааны ашиг		16,489,636	10,321,931
Орлогын албан татвар	23	(4,715,698)	(2,943,258)
Татварын дараах цэвэр ашиг		11,773,938	7,378,673

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тодруулга	← Үл хуваарилагдах →					Хуваарилагдах Нийт мян. төг
	Хувьцаат капитал мян.төг	Шагналт хувьцаа мян.төг	Дахин үнэлгээний сан мян.төг	Хуримт— лагдсан ашиг мян.төг		
2005 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	5,150,691	2,749,721	3,152,619	11,677,497	22,730,528	
Тайлант жилийн цэвэр ашиг	—	—	—	7,378,673	7,378,673	
Гаргасан хувьцаат капитал	1,456,786	4,625,601	—	—	6,082,387	
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	7	—	—	1,649,450	—	1,649,450
Шилжүүлсэн нөөц	—	—	(21,487)	21,487	—	
2005 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	6,607,477	7,375,322	4,780,582	19,077,657	37,841,038	
Тайлант жилийн цэвэр ашиг	—	—	—	11,773,938	11,773,938	
Гаргасан хувьцаат капитал	2,636	16,870	—	—	19,506	
Хувьцааны төлбөр	16	—	—	65,520	65,520	
Шилжүүлсэн нөөц	—	—	(1,012)	1,012	—	
2006 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	6,610,113	7,392,192	4,779,570	30,918,127	49,700,002	

Худалдаа Хөгжлийн Банк ХХК

2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулгууд

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2006 мян.төг	2005 мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	16,489,636	10,321,931
Тохируулга		
Элэгдэл, хорогдол	1,048,332	861,808
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	–	11,576
Данснаас хассан үндсэн хөрөнгө	45,226	–
Үндсэн хөрөнгө борлуулсны олз /(гарз)	(1,350)	76,709
Үнэлгээний бууралтын алдагдлын сан	1,630,679	2,092,626
Хувьцааны төлбөрт зориулсан гүйлгээ	65,520	–
Үйл ажиллагааны актив, пассивын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	19,278,043	13,364,650
Зээл ба урьдчилгааны өсөлт	(83,302,894)	(72,845,378)
Бусад хөрөнгийн өсөлт	(5,699,989)	(1,110,685)
Харилцагчдын харилцах, хадгаламжийн бууралт (өсөлт)	98,436,252	90,859,474
Бусад банк, санхүүгийн байгууллагуудын байршуулсан харилцах, хадгаламжийн өсөлт	(1,186,701)	7,450,411
Бусад өр төлбөрийн өсөлт	(73,592)	2,987,798
	27,451,119	40,706,270
Төлсөн орлогын албан татвар	(4,336,903)	(2,274,040)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	23,114,216	38,432,230

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Хөрөнгө оруулалтын үнэт цаасны цэвэр өсөлт, бууралт	19,101,555	(22,639,681)
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(3,486,866)	(1,355,982)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(566,114)	(107,796)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	25,617	2,967
Худалдан авсан хувьцаагаарх үнэт цаас	(61,350)	–
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	15,012,842	(24,100,492)

Худалдаа Хөгжлийн Банк ХХК

2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулгүүд

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2006 мян.төг	2005 мян.төг
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хувьцааны орлого	19,506	6,082,387
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн орлого	14,014,837	1,390,712
Бусад зээлийн орлого		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	14,034,343	7,473,099
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)	52,161,401	21,804,837
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн тайлант жилийн эхний үлдэгдэл	82,781,632	60,976,795
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн тайлант жилийн эцсийн үлдэгдэл	4 134,943,033	82,781,632

Худалдаа Хөгжлийн Банк ХХК

2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулгууд

I. Банкны талаарх мэдээлэл ба үндсэн үйл ажиллагаа

Тус Банкны толгой компани нь Швейцарь улсын Банка Коммерциале Лугано болон АНУ-ын Стэмфордын Жералд Металс компаниудын хамтран байгуулсан Люксембургт бүртгэлтэй Глобул Инвестмент энд Девелопмент компани байсан юм. Тайлант жилд Жералд Металс компани нь Глобул Инвестмент энд Девелопмент компани дахь Банка Коммерциале Лугано-ийн эзэмшлийн хэсгийг худалдан авсан.

Тайлант жилийн дараа Жералд Металс компани нь Глобул Инвестмент энд Девелопмент дахь өөрийн эзэмшлийн хэсгээ Ю.С. Глобал Инвестмент компанид зарж, улмаар тус банкны эцсийн эзэмшигч нь Ю.С. Глобал Инвестмент компани болсон юм.

Ю.С. Глобал Инвестмент компани нь Улаанбаатар Хотын Банк, Капитрон Банк, Сэнтрал Азия Майнинг ХХК болон тус банкны одоогийн ТҮЗ-ийн дарга н. Должингийн Эрдэнэбилэг нарын байгуулсан консорциум юм.

Тус Банк нь Монголбанкнаас олгосон 8 тоот лицензийн дагуу банкны болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэх үндсэн үйл ажиллагаа явуулдаг. Тус санхүүгийн жилийн явцад үндсэн үйл ажиллагааны цар хүрээнд ямар нэгэн томоохон өөрчлөлт гараагүй байна.

Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн 2007 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн шийдвэрийн дагуу эдгээр санхүүгийн тайлангуудыг нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн болно.

2. Санхүүгийн тайлангийн бэлтгэлийн үндэслэл

(а) Нийцэлтийн талаарх мэдэгдэл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын (СТОУС) дагуу бэлтгэгдсэн.

(б) Хэмжилтийн үндэслэл

Санхүүгийн тайлангуудыг зах зээлийн өргөөр нь тусгадаг үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон борлуулахад бэлэн буй санхүүгийн хөрөнгүүдийг эс тооцвол түүхэн өргийн зарчмаар бэлтгэсэн.

(в) Тайлан гаргасан болон үйл ажиллагааны валют

Тайланг төгрөгөөр, нэгжийн оронг мянгачилан гаргасан болно. Монгол төгрөг нь тус банкны үйл ажиллагааны валют юм.

(г) Ойролцоо тооцоолол болон дүгнэлт шийдвэрүүдийн хэрэглээ

Санхүүгийн тайлангуудын хувьд тус Банкны удирдлагын зүгээс шийдвэр, дүгнэлт гаргах, мөн ойролцоо тооцоолол хийх, таамаглал хийх шаардлагатай байдаг. Эдгээр шийдвэр, дүгнэлт, ойролцоо тооцоолол, таамаглал нь санхүүгийн тайлангуудад хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогууд, тайлагнасан актив, пассив, орлого, зарлагын дүнд нөлөөлдөг тул бодит гүйцэтгэл нь дээрх таамаглал, ойролцоо тооцоонаас өөр байж болзошгүй юм.

Ойролцоо тооцоолол болон түүний үндэс болох таамаглалыг тухайн үе болгонд хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн ойролцоо тооцооллын ямар нэгэн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт гарсан үе болон тухайн өөрчлөлтөөс хамаарах ирээдүйн тооцоололд хамруулан тайлагнана.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого

Дор дурьдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг Банк туштай баримталдаг бөгөөд өмнөх жилүүдэд хэрэглэж байсан бодлогуудтай зарчмын хувьд адил байна.

(a) Гадаад валютын гүйлгээ

Гадаад валютын гүйлгээ нь тухайн өдрийн тухайн валютын арилжааны ханшаар хөрвүүлж хийгддэг. Гадаад валютаар илэрхийлэгддэг бөгөөд түүхэн өртгөөр бүртгэлд тусгагддаг мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг мөн тухайн өдрийн валютын ханшаар хөрвүүлэн бүртгэнэ. Хөрвүүлэлтээс бий болох ханшийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигддэг мөнгөн бус хөрөнгө ба өр төлбөрийг гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар хөрвүүлэн тооцно. Харин бодит үнэ цэнээр бүртгэлд тусгагддаг, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө ба өр төлбөрийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн гадаад валют солилцооны ханшийг үндэслэн төгрөгт хөрвүүлнэ.

(б) Санхүүгийн хэрэгслүүд

(i) Ангилал

Арилжааны хэрэгслүүдэд Банк нь үндсэндээ богино хугацаанд арилжаалах, төлбөрийн чадварын удирдлагын зорилгоор эзэмшиж байгаа хэрэгслүүд орно. Үүнд тодорхой дериватив гэрээнүүдийг хамруулах бөгөөд эдгээрийг ханшны зөрүүнээс ашиголж болох үр дүнтэй хэрэгсэл гэж тодорхойлохгүй. Цэвэр авлагын позицтай (эерэг бодит үнэ цэнэтэй) арилжааны бүх деривативүүд болон худалдан авсан опционуудыг арилжааны хөрөнгө гэж тайлагнана. Цэвэр өглөгийн позицтай арилжааны бүх деривативууд мөн гаргасан опционуудыг арилжааны өр төлбөр гэж тайлагнана.

Үүсгэсэн зээл ба авлагад богино хугацаанд арилжаалагдах зорилгоор бий болгосон хэрэгслүүдээс бусад, харилцагчдад олгосон зээл болон авлагууд орно. Үүнд харилцагчдад олгож буй зээл ба урьдчилгаа багтана.

Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгөнд Банк дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хандлага болон чадвартай, тогтмол эсвэл тодорхойлогдох боломжтой төлбөр ба дуусгавар хугацаатай санхүүгийн хөрөнгүүд орно. Үнд банкны эзэмшиж буй хөрөнгө оруулалтын тодорхой үнэт цаас багтана.

Борлуулахад бэлэн хөрөнгөд арилжааны бус зорилгоор эзэмшиж байгаа, банк өөрөө үүсгээгүй эсвэл дуусгавар хугацаа хүртэл нь эзэмшихгүй хөрөнгүүд орно.

(ii) Эхний хүлээн зөвшөөрөлт

Банк санхүүгийн хэрэгслүүдийг худалдаж авах эсвэл гаргах үед санхүүгийн хэрэгслүүдийг өргөөр нь эхэлж бүртгэдэг бөгөөд энэ нь бодит үнэ цэнэтэй нь тэнцэнэ.

Хэрэв ямар нэгэн арилжаа, гүйлгээ нь зах зээлийн үнэд тулгуурлаагүй эсвэл зах зээлийн үнийг нь шууд тодорхойлох боломжгүй бол, ирээдүйд гарах төлбөр, орох орлогын ойролцоо тооцооллыг ижил төстэй санхүүгийн хэрэгслийн зах зээлийн хүүгийн өнөөгийн үнэ цэнийг үндэс болгож бодит өргтийг ойролцоогоор тогтоодог. Санхүүгийн хэрэгслийн бодит өртөг болон зах зээлийн үнийн зөрүүг санхүүгийн тайлан бэлтгэх олон улсын стандартын холбогдох заалтын дагуу хөрөнгө, өр төлбөр хэмээн тодорхойлогдох боломжгүй л бол шууд орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

(iii) Дараах үеийн хэмжилт

Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа идэвхтэй зах зээл дээр зах зээлийн санал болгох үнэгүй бөгөөд зах зээлийн бодит үнийг тодорхойлох боломжгүй хөрөнгүүдээс бусад бүх арилжааны хэрэгсэл, худалдах боломжтой хөрөнгүүд нь зах зээлийн үнээрээ хэмжигдэн, анхны өргөөс үнийн бууралтын алдагдлыг хассан цэвэр өргөөр тусгагддаг. Арилжааны хэрэгслүүд, худалдах боломжтой хөрөнгийн бодит үнийн өөрчлөлтөөс үүсэх ашиг алдагдлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба өмчийн өөрчлөлтийн тайланд шууд тусгадаг байна.

Арилжааны бус зориулалттай санхүүгийн өр төлбөрүүд, анхдагч зээл болон авлага, дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгүүдийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан үнэлгээний бууралтын алдагдлынх нь дүнгээр хорогдуулж бүртгэдэг. Ажил гүйлгээний өргтийг хамруулсан урамшуулал болон хөнгөлөлтийн дүнг холбогдох санхүүгийн хэрэгслийн нэрлэсэн үнэд шингээдэг бөгөөд үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан тооцдог.

(в) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, Монголбанк болон бусад банкинд байршуулсан харилцах, хадгаламжаас бүрдэнэ.

(г) Зээл ба Үрьдчилгаа

Тус банкны олгосон зээл ба үрьдчилгааг зээл ба авлага гэж ангилан бүртгэнэ. Тооцоолсон эргэн төлөгдөх дүнг харуулах зорилгоор зээл ба үрьдчилгааг болзошгүй эрсдлийн сангийн дүнг хассан цэвэр дүнгээр нь тайлагнана. (Нягтлан бodoх бүртгэлийн үндсэн бодлого хэсгийн (з)-г уншина уу).

(e) Үндсэн хөрөнгө

(i) Өртөг

Үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл (дараагийн хэсгийг уншина уу) болон үнэ цэнийн бууралтын алдагдал (Нягтлан бodoх бүртгэлийн үндсэн бодлого хэсгийн (з)-г уншина уу) –ыг хассан дүнгээр тайлагнадаг. Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, импортын албан татвар, эргэн төлөгдөх нөхцөлгүй худалдан авалтын татвар болон хөрөнгийг товлосон газарт нь зориулалтаар нь ашиглалтанд оруулахад гарах шууд зардлуудыг гарсан хугацааных нь орлого, үр дүнгийн тайландаа хүлээн зөвшөөрнө. Гарсан зардал нь үндсэн хөрөнгийн стандарт гүйцэтгэлийг нэмэгдүүлж, үндсэн хөрөнгийн ашиглалтаас ирээдүйд орж ирэх эдийн засгийн үр ашгийг өсгөж байгаа тохиолдолд тэдгээр зардлыг үндсэн хөрөнгийн нэмэгдсэн өртөг болгон капиталжуулж болно.

Банк нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бодит үнэ болон дансны үнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх зорилгоор дахин үнэлгээг тогтмол хийдэг.

Дахин үнэлгээнээс бий болсон илүүдэл нь дахин үнэлгээний нөөцийн дансанд бүртгэгдэх ба бий болсон дутагдал нь тухайн хөрөнгийн өмнөх жилийн өсөлтөөс хэтрэхгүй дүнгээр дахин үнэлгээний нөөцийн данснаас хасдаг. Бусад тохиолдолд, хөрөнгийн дансны үнийн бууралт нь орлогын тайландаа тусгагдана.

(ii) Элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг үндсэн хөрөнгийн төрөл бүрээр ашиглалтын жилийг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулдаг. Банкны үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа дараах байдалтай байна:

- Барилга 40 жил
- Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл 10 жил
- Компьютер 5 жил

(ё) Дуусаагүй барилга

Дуусаагүй барилга нь бүрэн дуусаагүй буюу сууринуулаагүй шинэ барилгуудын өртгийг илэрхийлнэ. Дуусаагүй барилгад ямар нэгэн элэгдэл байгуулдаггүй.

(ж) Биет бус хөрөнгө

(i) Гүүдвил

Гүүдвил нь хөрөнгийн худалдан авалтын өртөг нь тухайн хөрөнгийн цэвэр зах зээлийн бодит үнээс илүү гарсан дүнгээр илэрхийлэгддэг бөгөөд үнэлгээний бууралтын алдагдлын хуримтлагдсан дүнгээрээ багасч тусгагддаг. (Няглан бodoх бүртгэлийн үндсэн бодлого хэсгийн (з)-г уншина уу)

(ii) Өртөг

Банкны худалдан авсан биет бус хөрөнгийг түүний өртөгөөс хуримтлагдсан элэгдэл (дараагийн хэсгийг уншина уу) болон үнэ цэнийн бууралтын алдагдал (Няглан бodoх бүртгэлийн үндсэн бодлого хэсгийн (з)-г уншина уу)—ыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

(iii) Хорогдуулга

Ашиглалтын хугацаа нь тодорхой биш л бол биет бус хөрөнгийг тооцоолсон ашиглалтын хугацааных нь туршид шулуун шугамын аргаар хорогдуулж орлого, үр дүнгийн тайландаа зардлаар хүлээн зөвшөөрнө. Биет бус хөрөнгийн ашиглагдах хугацаа дараах байдалтай байна:

Программ хангамж, лиценз – 5 жил

(з) Үнэлгээний бууралт

Банкны хөрөнгийн дансны үнийг тайлан баланс гаргах бүр тооцдог бөгөөд ингэхдээ ямар нэг үнэлгээний бууралтын алдагдал байгаа эсэхийг шалгадаг. Хэрэв тийм шинж тэмдэг ивэрвэл тухайн хөрөнгийн нөхөж болох дүнг тооцож гаргадаг.

(i) Анхдагч зээл ба урьдчилгаа

Зээл болон урьдчилгааг болзошгүй алдагдлын санг хассан цэвэр дүнгээр нь тайлагнадаг. Хасагдуулгыг балансын тогтмол хяналтын үр дүнд алдагдал үүсч болзошгүй хэмээн тодорхойлсон зээл эсвэл урьдчилгааны эргэн төлөгдөх боломжтой цэвэр дүнг тодорхойлох зорилгоор тогтмол байгуулж тэдгээрийн дансны үнээс нь хасч бүртгэдэг. Хасагдуулгын дансны өсөлтийг орлогын тайландаа тусгадаг. Хэрэв олгосон зээлийг эргэн төлөгдөх боломжгүй болсон гэж үзвэл, хуулийн хүрээнд зохих бүхий л арга хэмжээг авах бөгөөд гарч болох алдагдлын нийт дүнг тодорхойлж тухайн зээлийг данснаас шууд хасдаг.

Хэрэв алдагдлын хэмжээ нь хожим багассан байна гэж тодорхойлогдсон бөгөөд энэхүү бууралт нь хасалт хийгдсэнээс хойш болсон ямар нэгэн үйл явдалтай холбоотой бол хасалдуулгыг буцааж орлогын тайландаа залруулга хийдэг.

(ii) Зээл ба урьдчилгаанаас бусад хөрөнгүүд

Эргэн нөхөгдөх боломжтой дүн нь хөрөнгийн борлуулах цэвэр боломжит үнэ ба ашиглалтанд байгаа үнэ цэнийн аль илүү нь болж өгдөг. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн тухайн үеийн зах зээлийн үнэлгээ болон тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдлийг тусгадаг татварын өмнөх хямдруулалтын түвшинг ашиглан тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хүртэл нь хямдруулж ашиглалтанд байгаа үнэ цэнийг үнэлнэ. Мөнгөний орох урсгал бий болгодоггүй, бусад хөрөнгөөс тусдаа хөрөнгүүдийн хувьд эргэн нөхөгдөх дүнг тухайн хөрөнгийн харьялгаж буй мөнгө орох урсгал бий болгодог хөрөнгийн нэгжийн хувьд тодорхойлдог. Хөрөнгийн эсвэл мөнгө орох урсгал бий болгодог хөрөнгийн нэгжийн дансны үнэ нь эргэн нөхөгдөж болох үнээсээ давсан үед үнийн бууралтын алдагдлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Эргэн нөхөгдөх дүнг тодорхойлоход ашигласан ойролцоо тооцоололд өөрчлөлт орсон бол үнийн бууралтын алдагдлыг буцаадаг. Үнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй бол тодорхойлогдсон элэгдэл хорогдлыг хассан цэвэр дансны өртгөөс тухайн хөрөнгийн дансны үнэ хэтрэхгүй байх нөхцөлд л үнийн бууралтын алдагдлыг буцаадаг. Үнийн бууралтын алдагдлын бүх буцаалтыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

(и) Буцаан худалдан авалтын гэрээнүүд

Банк нь тодорхой хугацаанд, тогтсон үнээр мөн чанарын хувьд ижил төрлийн хөрөнгө оруулалтыг дахин худалдан авах (худалдах) гэрээний дагуу хөрөнгө оруулалтыг эргэн худалдан авах (эргэн худалдах) үйл ажиллагаа явуулдаг. Дараа нь эргэн худалдах эсвэл эргэн худалдан авах нөхцөлтэй хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрөхгүй.

Төлсөн дүнг банкуудад эсвэл харилцагчдад олгосон зээлийн дансанд бүртгэдэг. Авлагуудыг тухайн үнэт цаасаар барьцаалагдсан гэж бүртгэдэг. Эргэн худалдан авалтын гэрээний хүрээнд борлуулсан хөрөнгө оруулалтуудыг балансад тусгаж үлдээдэг бөгөөд мөнгөн дүнг нь арилжааны үнэт цаас эсвэл борлуулах боломжтой үнэт цаасны бүртгэлийн бодлогын аль тохиromжтойг нь хэрэглэж тооцож гаргадаг. Хөрөнгө оруулалт борлуулснаас орох орлогыг банк эсвэл харилцагчдад өгөх өглөг гэж бүртгэлд тусгадаг. Борлуулалт болон дахин худалдан авалтын зөрүүг тайлант үеийн турш тохируулах суурьтай (аккруэл суурьтай) бүртгэлийн аргаар бүртгэж дансанд тусгадаг ба хүүгийн дунд ордог.

(й) Арилжааны бус санхүүгийн өр төлбөр

Арилжааны бус санхүүгийн өр төлбөр гэдэгт харилцагчид, бусад санхүүгийн байгууллагаас татсан харилцах, хадгаламж, хүү бүхий зээллэг болон бусад өглөгүүд орно. Арилжааны бус өр төлбөрийг анх өртгөөр нь тусгадаг. Эхний хүлээн зөвшөөрөлтөөс хойш тэдгээр нь хорогдуулсан өртөг буюу өртөг болон үлдэх өртгийн хоорондын зөрүүгийн хамт тусгагдан, үр ашигт хүүгийн аргаар тухайн хэрэгслийн хугацааны турш орлогын тайланд хүлээн зөвшөөрөгддөг.

(к) Болзошгүй эрсдлийн сан

Банк нь өмнөх үеийн үйл явдлын үр дүнд хууль ёсны буюу бодит хариуцлага хүлээж буй болон эдийн засгийн үр өгөөжийн гарах урсгалд хариуцлагаа биелүүлэх шаардлагатай байх үед балансад болзошгүй эрсдлийн санг хүлээн зөвшөөрдөг. Нөлөөлөл нь материаллаг бол мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн зах зээлийн үнэлгээг тусгадаг татварын өмнөх түвшин болон тохиромжтой бол тухайн өр төлбөрт хамааралтай эрсдлээр нь ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг хямдруулах замаар болзошгүй эрсдлийн сангийн дүнг тодорхойлдог.

(л) Орлого

(i) Хүүгийн орлого

Хүүгийн орлого ба зардлыг хуримтлуулан бүртгэж, хөрөнгийн үр ашигт өгөөжийг харгалзан орлогын тайланда хүлээн зөвшөөрдөг. Хүүгийн орлого зардал нь хямдруулалт буюу урамшуулалт, хүү бүхий хэрэгслийн дансны үнэ болон үр ашигт хүүгийн түвшний сууриар тооцсон дуусгавар хугацаан дахь дүнгийн хоорондын зөрүүний элэгдүүлэлт, хорогдлыг агуулдаг.

(ii) Хураамж шимтгэлийн орлого

Хураамж шимтгэлийг үзүүлсэн санхүүгийн үйлчилгээнийхээ төлөө харилцагчдаас авдаг. Төлбөр хураамжийн орлогыг холбогдох үйлчилгээг үзүүлэх үед хүлээн зөвшөөрдөг.

(iii) Түрээсийн орлого

Түрээслэсэн хөрөнгийн түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар орлогын тайланда хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн урамшууллыг нийт түрээсийн орлогын салшгүй хэсэг болгон хүлээн зөвшөөрдөг.

(м) Үйл ажиллагааны түрээсийн төлбөр

Түрээсийн зардлыг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар орлогын тайланда хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн урамшууллыг нийт түрээсийн зардлын салшгүй хэсэг болгон орлогын тайланда түрээсийн нийт хугацааны хувьд хүлээн зөвшөөрдөг.

(н) Орлогын татвар

Тайлант жилийн ашиг эсвэл алдагдалд ногдох орлогын татвар нь тайлант үеийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Өмчөөр шууд хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл бүхий зүйлстэй холбоотой татварыг өмчөөр хүлээн зөвшөөрдөг. Үүнээс бусад тохиолдолд орлогын татварыг орлогын тайланда хүлээн зөвшөөрдөг.

Тайлант үеийн татвар нь балансын өдрөөр хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувийг ашиглан тооцсон тухайн жилийн татвар ногдох орлогод ногдуулсан хүлээгдэж буй татварын өглөг болон өмнөх жилүүдийн татварын өглөгт хийсэн залруулга болно.

Хойшлогдсон татварыг балансын өр төлбөрийн аргыг ашиглан, санхүүгийн тайлангийн зорилгоор тооцоолсон дүн болон татварын зорилгоор тооцоолсон хөрөнгө өр төлбөрийн дансны үнийн дүнгийн хоорондох түр зөрүүгээр тооцоолдог. Няглан бодох бүртгэлийн ашиг болон татвар ногдох орлогод нөлөөлөхгүй хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлттэй холбоотой түр зөрүүнд хойшлогдсон татварыг тооцоолдоггүй.

Тооцоолсон хойшлогдсон татварын дүнг балансын өдрөөрх татварын хуулиар батлагдсан хувь хэмжээнүүдийг ашиглан, тухайн түр зөрүү арилах үед ногдуулаж болзошгүй татварын хувиар ногдуулж тооцно.

Хойшлогдсон татварын хөрөнгө нь ирээдүйн татвар ногдох орлого үүсэх бөгөөд түүнд энэхүү хойшлогдсон татварын хөрөнгийг ашиглагдах боломжтой тохиолдолд л балансад хүлээн зөвшөөрөгддөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе болгон хянаж холбогдох татварын өгөөж нь дахин хэрэгжих боломжгүй болтол хойшлогдсон татварын хөрөнгийг нь бууруулдаг.

(o) Ажиллагсдын тэтгэмж

(i) Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Ажиллагсдын тэтгэмж нь улсын нийгмийн даатгалын байгууллагад төлж буй нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийг агуулдаг. Энэхүү тодорхойлсон тэтгэмжийн төлөвлөгөөний тусlamжийг гарсан үед нь орлогын тайландаа зардлаар хүлээн зөвшөөрдөг.

(ii) Хувьцааны урамшуулалд үндэслэсэн төлбөрийн гүйлгээнүүд

Ажиллагсадад опционы эрх өгсөн өдрийн зах зээлийн үнээр хүний нөөцийн зардалд бичин цаашид уг опционыг авах эрхтэй болох хугацааны туршид нөгөө талд хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлнэ. Зардал болох дүнг эрхийг нь олгосон хэрэгжүүлээгүй үлдсэн опционы тоогоор тохируулна.

Ажиллагсдын опционы эрхийн зах зээлийн үнийг Black-Scholes томъёогоор тооцсон. Хэмжигдсэн өдрийн хувьцааны үнэ, хэрэгслийг хэрэгжүүлэх үнэ, хүлээгдэж байгаа хэлбэлзэл (олон нийтэд зарлагдсан мэдээлгүүдээс шалтгаалсан өөрчлөлтүүдийг тусгасан жигнэсэн дундаж түүхэн хэлбэлзэлд үндэслэсэн), хэрэгслийн хүлээгдэж буй хэрэгжих хугацааны жигнэсэн дундаж (түүхэн туршлага ба хувьцаа эзэмшигчдийн ерөнхий зан араншинд тулгуурласан) зэрэг нь өгөгдөл орсон болно. Зах зээлийн үнийг тодорхойлоходо гүйлгээтэй холбогдсон үйлчилгээ ба зах зээлийн бус гүйцэтгэлийн нөхцөлүүдийг авч үзээгүй болно.

(р) Хэрэгжүүлж эхлээгүй байгаа шинэ стандартууд ба тайлбарууд

Олон тооны СТОУС-ууд, СТОУС-уудын нэмэлтүүд болон тайлбарууд (Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын хороо (НББОУСХ)) нь 2006 оны 12-р сарын 31-ны өдрөөр төгссөн онд хүчин төгөлдөр болоогүй байсан бөгөөд эдгээр санхүүгийн тайланд тусгагдаагүй болно:

- СТОУС 7 Санхүүгийн хэрэгслүүд: Тодруулгууд ба НББОУС I-ийн нэмэлт Санхүүгийн тайлангийн танилцуулга: Хөрөнгийн тодруулгууд нь аливаа нэгжийн санхүүгийн байр суурь ба гүйцэтгэлийн хувьд санхүүгийн хэрэгслүүд нь хэр чухал болох талаар дэлгэрэнгүй тодруулга ба эрсдлийн байдал, цар хүрээний талаар чанар болон тоон хэлбэрийн тодруулгуудыг шаарддаг. Тус Банкны 2007 оны санхүүгийн тайлангуудад заавал тусгагдах СТОУС 7 ба нэмэлт хийгдсэн НББОУС I нь тус Банкны санхүүгийн хэрэгслүүд ба хувь нийлүүлсэн хөрөнгийн хувьд өргөн хүрээтэй нэмэлт тодруулгуудыг шаардах болно.
- НББОУС I Гипер инфляц бүхий эдийн засгуудын санхүүгийн тайлагналын дагуу НББОУСХ 7 Давтан мэдээллийн аргыг хэрэглэх нь аливаа эдийн засаг анх гипер инфляцтай болох үед НББОУС 29-ийн хэрэглээ ба тухайлбал хойшлогдсон татварын нягтлан бодох бүртгэлд хамаарна. Тус Банкны 2007 оны санхүүгийн тайлангуудад заавал тусгагдах НББОУСХ 7 нь санхүүгийн тайлангуудад ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болно.
- НББОУСХ 8 СТОУС 2-ын цар хүрээ хувь нийлүүлэлтэд тулгуурласан төлбөр нь хүлээн авсан зарим эсвэл бүх бараа эсвэл үйлчилгээ нь тодорхойлогдох боломжгүй хувь нийлүүлсэн төлбөрийн гүйлгээнүүдийн нягтлан бодох бүртгэлийг хамаарна. Тус Банкны 2007 оны санхүүгийн тайлангуудад заавал тусгагдах НББОУСХ 8 нь санхүүгийн тайлангуудад ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болно.
- НББОУСХ 9 хавсарсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн дахин үнэлэлт нь үүсмэл санхүүгийн хэрэгсэл бодит эх гэрээнээсээ тусгаарлагдах эсэхийг дахин үнэлэх нь зөвхөн гэрээнд өөрчлөлтүүд орсон тохиолдолд хийгдэх хэрэгтэй байхыг шаарддаг. Тус Банкны 2007 оны санхүүгийн тайлангуудад заавал тусгагдах НББОУСХ 9 нь санхүүгийн тайлангуудад ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болно.
- НББОУСХ 10 Түр хугацааны санхүүгийн тайлагнал ба үнэлгээний бууралт нь хувьцаат хөрөнгийн хэрэгсэл эсвэл санхүүгийн актив нь зардал гаргасан гүүдвилтэй холбоотой өмнөх түр хугацааны үед гарсан үнийн бууралтын алдагдлыг буцаан бүртгэхийг хориглоно. НББОУСХ 10 нь тус Банкны 2007 оны санхүүгийн тайлангуудад заавал тусгагдах бөгөөд тус Банк харгалzan НББОУС 36, НББОУС 39-ийг хэмжилтийн үзүүлэлтэд хэрэглэж эхэлсэн өдрөөс (ө.х. 2004 оны 1-р сарын 1) эхлэн гүүдвил, хувьцаат хөрөнгийн хэрэгслүүдэд хийсэн хөрөнгө оруулалтууд, зардал гаргасан санхүүгийн активуудад хамаарна. НББОУСХ 10 нь санхүүгийн тайлангуудад ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болно.

4. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

	2006 мян.төг	2005 мян.төг
Касс дахь бэлэн мөнгө	25,371,639	11,771,646
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	83,842,987	62,183,406
Монголбанк дахь харилцах, хадгаламж	25,728,407	8,826,580
	134,943,033	82,781,632

Монголбанкнаас тавигддаг шаардлагын дагуу хөрөнгийг Монголбанкинд байршуулдаг бөгөөд дансны үлдэгдэлд хүү тооцдоггүй. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө, өр төлбөрийн дундаж дээр үндэслэн Монголбанкинд байршуулах бэлэн мөнгөний үлдэгдлийг тооцоолж гаргадаг.

5. Хөрөнгө оруулалтын үнэт цаас

	2006 мян.төг	2005 мян.төг
Дүүсгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас		
Монголбанкны үнэт цаас	22,128,374	43,937,244
Засгийн Газрын үнэт цаас	802,981	–
Вексель	4,291,226	2,607,173
	27,222,581	46,544,417
Хуримтлагдсан хөнгөлөлт	300,541	80,260
Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	–	(26,072)
	27,523,122	46,598,605
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас		
Зарлагдсан үнэгүй хувьцаагаарх үнэт цаас	61,350	–
	27,584,472	46,598,605

6. Зээл ба урьдчилгаа

	2006 мян.төг	2005 мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	248,427,120	168,493,508
Ажиллагсдад олгосон зээл	3,423,345	417,042
	251,850,465	168,910,550
Зээлийн болзошгүй эрсдлийн сан	(11,744,380)	(12,183,074)
Цэвэр зээл ба урьдчилгаа	240,106,085	156,727,476

